



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН
ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ
ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ

Үндсэн ойлголт, зарчим, практик хэрэглээний гарын авлага

Нэгдүгээр хэвлэл

УЛААНБААТАР

20
24

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ

Гарын авлага боловсруулсан зөвлөх баг:

Д.Намхайдагва, Зөвлөх

Я.Бямбасүрэн, Зөвлөх

М.Эрдэнэбаяр, Зөвлөх

Г.Цэрэнжаргал, Зөвлөх

Б.Мягмарсүрэн, Зөвлөх

Хянан тохиолдуулсан:

Л.Балчинлувсан,

Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга

Б.Мөнгөнсүх,

Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Энэхүү “Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт” гарын авлагыг “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

 978-9919-9059-9-6

Энэхүү гарын авлага нь Европын Холбооны санхүүжилтээр боловсруулагдсан бөгөөд төрийн бодлого, төлөвлөгөө боловсруулах үйл явцад оролцогчдод зориулсан. Гарын авлагын агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хариуцлага хүлээхгүй болно. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ	7
1. УДИРТГАЛ	8
2. ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ, ЗАРЧИМ, АРГА ЗҮЙ, ҮЕ ШАТ	9
2.1. Төрийн бодлого, төлөвлөлт ба үр дүн	9
2.2. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн арга зүй, үе шат	10
3. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ	17
3.1. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх арга зүй	17
Алхам 1. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээг тодорхойлох нь	17
Алхам 2. Оролцогч талын шинжилгээ болон үр шим хүртэгч ба зорилтот бүлгийг тодорхойлох нь	21
Алхам 3. Хэрэгцээ, асуудлыг тодорхойлох нь	26
Алхам 4. Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратеги/-ыг тодорхойлох нь	32
Алхам 5. Асуудлыг хэмжих үзүүлэлт, асуудлын хамрах хүрээ, тархалтын хурдыг тодорхойлох нь	34
Алхам 6. Тухайн түвшний хэрэгцээ, асуудлыг хангах үндсэн ба хамтрагч талуудыг тодорхойлох нь	36
3.2. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хүрээнд гаргаж буй нийтлэг алдаа ба зөвлөмж	38
3.3. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хүрээнд оролцогч талуудаас гарч буй нийтлэг асуулт ба хариулт	39
4. ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ	41
4.1. Үр дүнгийн шинжилгээ хийх арга зүй	41
Алхам 1. Үр дүнг тодорхойлох нь	42
Алхам 2. Үр дүнд хүрэх арга зам /стратеги/-ыг тодорхойлох нь	44
Алхам 3. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь он, түвшин болон зорилтот он, түвшинг тодорхойлох	44
Алхам 4. Үр дүнг хангах үндсэн болон хамтран хариуцагчийг тодорхойлох нь	47
Алхам 5. Хөтөлбөрийн гарц, түүний шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь	49
4.2. Үр дүнгийн шинжилгээ хийх хүрээнд гаргаж буй нийтлэг алдаа ба зөвлөмж	50
4.3. Үр дүнгийн шинжилгээ хийх хүрээнд оролцогч талуудаас гарч буй нийтлэг асуулт ба хариулт	52

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ажлын хүснэгт	17
Хүснэгт 2. Үндэсний түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээний жишээ	18
Хүснэгт 3. Салбарын ангиллын харьцуулалт ба санал болгож буй салбарын жагсаалт	19
Хүснэгт 4. Салбарын түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээний жишээ	20
Хүснэгт 5. ТЭЗ-ийн түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээний жишээ	20
Хүснэгт 6. Хөтөлбөрийн тодорхойлолтын маягт	22
Хүснэгт 7. Хөтөлбөрийн түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээний жишээ	25
Хүснэгт 8. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд үр шим хүртэгч ба зорилтот бүлгийг тодорхойлсон жишээ	27
Хүснэгт 9. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд хэрэгцээ, асуудал тодорхойлсон жишээ	33
Хүснэгт 10. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон жишээ	34
Хүснэгт 11. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон жишээ	37
Хүснэгт 12. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд асуудалд шууд холбогдогч талуудыг тодорхойлсон жишээ	42
Хүснэгт 13. Үр дүнгийн шинжилгээний ажлын хүснэгт	42
Хүснэгт 14. Үр дүн ба шалгуур үзүүлэлтийг ялгааг харуулсан жишээ	46
Хүснэгт 15. Үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин	48

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төрийн бодлогын үйл явц _____	10
Зураг 2. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хамрах хүрээ _____	10
Зураг 3. Төрийн бодлого, удирдлагын хүрээн дэх төлөвлөлтийн уялдааны зураглал _____	11
Зураг 4. Хөтөлбөрийн логик уялдааны загвар _____	13
Зураг 5. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хүрээнд хийх багц шинжилгээ буюу үе шат _____	13
Зураг 6. ҮДСНУ-ын хүрээнд санал болгож буй бодлого боловсруулалт, төлөвлөлтийн аргачлал _____	15
Зураг 7. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ хоорондын уялдаа _____	23
Зураг 8. Босоо түвшний шалтгаан, үр дагаврын шинжилгээний зураглал жишээ _____	21
Зураг 9. Хэвтээ түвшний шалтгаан, үр дагаврын шинжилгээний зураглал _____	21
Зураг 10. Үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнгийн жишээ _____	43

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1: Санал болгож буй салбарын жагсаалт ба тодорхойлолт	54
Хавсралт 2: Хэрэгцээ, асуудлыг түвшнээр ялгаж тодорхойлсон эсэхийг шалгах хуудас	57
Хавсралт 3: Салбарын хэрэгцээ, асуудал хоорондын хэвтээ түвшний уялдаа, хамаарал /ХНХС, ХХААХҮС-ийн жишээн дээр/	58
Хавсралт 4: Асуудлын хамрах хүрээ, тархалтын хурд, үр дагавраар нь асуудлыг эрэмбэлэх арга зүй болон жишээ	60
Хавсралт 5: Шалгуур үзүүлэлтийг хэр чанартай боловсруулсан эсэхийг нягтлах хяналтын хуудас	64
Хавсралт 6: Үр дүнг тодорхойлох SMART зарчим болон нөхцөл байдлын дүн шинжилгээ, үр дүнгийн шинжилгээ хоорондын уялдааг хангаж боловсруулсан эсэхийг нягтлах хяналтын хуудас	65

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УИХ	Улсын Их Хурал
ҮДСНУ	Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага
ХАА	Хөдөө аж ахуй
ХБТТУТХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам

1 УДИРТГАЛ

“Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт” гарын авлагыг ЕХ-ны санхүүжилтээр НҮБХХ-ийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл явцад оролцогчдод зориулан боловсруулав.

Уг төсөл нь 2020-2024 оны хооронд хэрэгжиж байгаа бөгөөд төслийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь Тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулан Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналын нэгдсэн тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Төслийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн бодлого, удирдлагын эрх зүйн орчныг шинэчлэх, Арга аргачлалыг боловсронгуй болгох, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, Хөтөлбөрт суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг бэхжүүлэн Төрийн бодлогын үр дүн, үр нөлөөг сайжруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллах явцад хуримтлуулсан туршлага, сургамж, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудалд тулгуурлан Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын (ҮДСНУ) бүрэлдэхүүн хэсэг болох Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн үндсэн арга зүйг Монгол Улсын нөхцөлд нийцүүлэн нутагшуулахад практик хэрэглээ болохуйц талаас нь анхаарч энэхүү гарын авлагыг боловсруулахыг зорьсон.

Улс орнууд Үр дүнд суурилсан удирдлагын тогтолцоог хөгжүүлэхийг нэн тэргүүний зорилт болгож, зөв засаглалыг бэхжүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэн хүн төвтэй, тогтвортой хөгжилд тэмүүлж байна.

Хүн төвтэй, тогтвортой хөгжлийг бий болгохын тулд хөгжлөөс хэнийг ч орхихгүй байх, хүний суурь эрх, эрх чөлөөг эрхэмлэх, хөгжлийн бодлого, удирдлагад жендэрийн мэдрэмжтэй байх зэрэг зарчимд нийцүүлэн хөгжлийн хүрээнд хүлээгдэж буй үр дүнг тодорхойлж, хэрэгжилтийг хангах шаардлага үүсэж байна. Үүний нэг илрэл нь 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ)-ыг дэлхий нийтээр хэрэгжүүлэхийг албан ёсоор уриалсан санаачилга юм.

Иймд улс орнууд тогтвортой хөгжилд хүрэх үндсэн арга зам нь үр дүнд суурилсан удирдлага хэмээн үзэж, улс орон бүр өөрийн онцлогт тохирсон арга, аргачлалыг боловсруулан хэрэгжүүлж, тэрхүү үр дүндээ суурилсан хөгжлийн бодлого, төлөвлөлт, улсын болон орон нутгийн төсөв, байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөлтийг уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна. Энэхүү үйл хэрэгт хувь нэмэр оруулах үүднээс энэхүү гарын авлагыг боловсруулав.

2 ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ, ЗАРЧИМ, АРГА ЗҮЙ, ҮЕ ШАТ

2.1. ТӨРИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ БА ҮР ДҮН

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт нь үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд одоо, өнгөрсөнд дүн шинжилгээ хийж, ирээдүйг төлөвлөх үйл явц юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Монгол Улсын хөгжлийг урт, дунд, богино хугацаанд хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичгийн хүрээнд тодорхойлохоор хуульчилсан. Энэ нь эхлээд бодлогоо тодорхойлох, түүнийг нарийвчлан төлөвлөх гэсэн дараалалтай үйл ажиллагаа хийгдэхийг харуулж байна.

Энэхүү гарын авлагад ашиглагдаж буй Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт нь бодлого боловсруулалт, төлөвлөлт гэсэн санааг нэгтгэсэн ойлголт болно.

Төрийн бодлогыг бүрэн танин мэдэхийн тулд төрийн бодлогын үйл явцын логик холбоог ойлгох нь чухал. Төрийн бодлогын хүрээнд бодлогын орц, үйл ажиллагаа, гарц, бодлогын зорилго, зорилт буюу бодлогын үр дагавар, үр нөлөө хэмээх ойлголтууд хөндөгддөг. Бодлогын үр дагавар, үр нөлөөг бүхэлд нь бодлогын үр дүн хэмээн тодорхойлж байна.

Төрийн бодлогыг үйл явц талаас нь авч үзвэл тодорхой орцыг татан төвлөрүүлж, хуваарилсны үндсэн дээр төрийн холбогдох байгууллага, албан хаагчид үйл ажиллагаа хэрэгжүүлж, үйл ажиллагааны эцэст холбогдох талуудад гарц буюу бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлж, тэрхүү бүтээгдэхүүн, үйлчилгээний шууд болон дам нөлөөгөөр үр дүн бий болгохыг зорьж буй зорилтот үйл ажиллагаа юм.

Энэхүү үр дүн нь төрийн чиг үүрэгтэй уялдаатай бөгөөд төрийн үндсэн чиг үүргийг хамгийн ерөнхий байдлаар ард түмний сайн сайхан, аюулгүй байдлыг хангах буюу

- о Нийгмийн харилцааг зохицуулах,
- о Нийтлэг эрх ашгийг хамгаалах,

хэмээн тодорхойлж болох юм. Эндээс авч үзвэл бодлогын үр дүн гэдэг нь ард түмний амьдралын чанар, аюулгүй байдал, иргэдийн нийтлэг эрх ашиг, улс орны хөгжил, нийгмийн харилцаанд гарах өөрчлөлт юм.

Төрийн бодлогын үйл явцыг дараах зураглалаар илэрхийлж болно. Үүнд:

Зураг 1. Төрийн бодлогын үйл явц




Дээрх зураглалд дурдагдсан ойлголтыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- **Орц** - Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах цаг хугацааны, хүний, санхүүгийн, материалын (мөнгөн бус) болон институцийн чадамж (технологийн болон мэдээллийн гэх мэт)
- **Үйл ажиллагаа** - Орцыг ашиглан бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас хэрэгжүүлж буй багц арга хэмжээ, ажил
- **Гарц** – Бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны эцэст холбогдох талуудад нийлүүлж байгаа эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ
- **Үр дагавар** - Гарцаас шууд хамаарч бий болох өөрчлөлт
- **Үр нөлөө** - Гарцаас дам, үр дагавраас шууд хамааралтайгаар бий болох өөрчлөлт

Төрд олгогдсон эрх, үүрэг болон бодлогын үйл явц нь үр дүнг удирдах, түүнд нөлөөлөх боломжийг олгодог.


Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хүрээнд орц, үйл ажиллагаа, гарц, үр дүнг логик уялдаатай төлөвлөдөг.

Зураг 2. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хамрах хүрээ



Монгол Улсын төрийн бодлого, удирдлагын эрх зүйн өнөөгийн орчны хүрээнд үр дүнг төлөвлөх үйл явцын эцэст гарах бүтээгдэхүүнийг /баримт бичиг/ дараах зураглалаар илэрхийлж болно.

Зураг 3. Төрийн бодлого, удирдлагын хүрээн дэх төлөвлөлтийн уялдааны зураглал



Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт нь дараах үндсэн зарчимд үндэслэдэг. Үүнд:

SMART буюу тодорхой, хэмжигдэхүйц, бодитой, хамааралтай, хугацаатай байх

Төлөвлөлтийн хүрээнд тодорхойлсон үр дүн нь энгийн ойлгомжтой, хоёрдмол утгагүй байх; үр дүн тодорхойлсон бол түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг тодорхойлдог байх; үр дүнг судалгаа, баримт нотолгоонд үндэслэж хэрэгжихүйц, бодитой тодорхойлдог байх; үр дүн нь үр шим хүртэгч болон бусад оролцогч талын бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн, салшгүй холбоотой байх; үр дүнг хангах хугацаа буюу суурь он, зорилтот оныг тодорхойлдог байх;

Нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх

Бүх шатанд хийж буй төлөвлөлт хоорондын уялдааг хангадаг байх; тухайн төлөвлөлтийн хүрээнд тодорхойлогдсон үр дүн хоорондын хэвтээ болон босоо уялдааг хангасан байх. Өөрөөр хэлбэл үр дүн хоорондын уялдаа, хамаарлыг оновчтой тодорхойлсон байх;

Судалгаа, шинжилгээ, баримт нотолгоонд үндэслэсэн байх

Бодлого, төлөвлөлтийн хүрээнд хөндөгдөж буй асуудал, түүний шалтгаан үр дагаврын уялдаа, хамаарлыг хамгийн багадаа логик гаргалгаанд үндэслэн тодорхойлдог байх; Асуудлуудыг эрэмбэлэн зүй тогтол, хоорондын уялдаа, хамаарлыг логик шинжилгээнд үндэслэн тодорхойлж, асуудлыг үүсгэж буй үндсэн шалтгаанд төвлөрч баримт нотолгоонд суурилсан бодлогын шийдвэр гаргадаг байх;

Оролцогчдын үүрэг, хариуцлага тодорхой байх

Төлөвлөлтийн хүрээнд тодорхойлсон үр дүн, төсөл арга хэмжээг хариуцах үндсэн болон хамтран хариуцагчийг эрхлэх асуудлын хүрээ, чиг үүрэгтэй уялдуулан тодорхойлдог байх; Хариуцлагын хүрээ, хяналтын хүрээний зааг ялгааг оновчтой тодорхойлдог байх;

Энэхүү гарын авлагын дараагийн хэсгүүдэд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх практик хэрэглээний асуудлыг хөндөж авч үзнэ.

2.2. ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТИЙН АРГА ЗҮЙ, ҮЕ ШАТ


Үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүй нь дараах зүйлсэд чиглэж байна. Үүнд:

- Бүх шатанд хийж буй төлөвлөлтийг хооронд нь уялдуулах
- Төлөвлөлтийг үйл ажиллагаа, арга хэмжээ, төслөөр хязгаарлан боловсруулах бус үр дүнг хангахад чиглүүлэх
- Үр дүнг түвшин, хүрэх хугацаагаар нь ялгаж хэвтээ болон босоо түвшинд уялдуулан төлөвлөх
- Үр дүнг тодорхойлохдоо асуудал, үр дагаврыг арилгахад бус асуудлын үндсэн шалтгааныг арилгахад чиглүүлэх
- Үндэсний асуудалд төвлөрч бусад асуудлыг эрэмбэлэн зүй тогтол, дараалалтайгаар шийдвэрлэх бодлого боловсруулах
- Үр дүнг бүрэн хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох
- Хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлж, мөшгөн нягталж, алдаанаас сургамж авч сайжруулах
- Сэтгэл хөдлөлд бус баримт нотолгоонд суурилсан бодлого, шийдвэр гаргадаг байх
- Үр дүнг хариуцах эзнийг тодорхой болгох
- Үр дүнг санхүүжүүлэх
- Нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн үндсэн арга зүй нь логик уялдааны загвар бөгөөд логик шинжилгээг бүх түвшинд ашиглахыг шаарддаг ба түвшнүүд нь “үр дүнгийн хүрээ”-гээр хоорондоо системтэй холбогдоно. Энэхүү загварчлал нь уламжлалт болон хялбаршуулсан орц, үйл явц, гарц, үр дүнгийн логик загварыг нэгтгэсэн загвар юм.

Логик уялдааны загвар нь оролцогч талууд болон нийгмийн зорилтот бүлгийн хэрэгцээ, асуудлыг нарийвчлан шинжилсэн эрэлтийн буюу нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн хэрэгцээ, асуудлыг уялдуулан тодорхойлж, түүнд тодорхой хугацааны дараагаар гарах өөрчлөлт буюу үр дүнг төлөвлөдөг. Мөн үр дүнд хүрэх арга зам буюу стратегийг тодорхойлж хөтөлбөрөөр багцлан хэрэгжүүлдэг. Хөтөлбөр нь зорилтот үр дүнг бий болгох гарц, гарцыг бий болгох багц “арга хэмжээ” эсвэл “үйл явц”-аас бүрдэнэ.


Зураг 4. Хөтөлбөрийн логик уялдааны загвар



Эх сурвалж: Сургалтын материал, НҮБХХ-ийн төслийн зөвлөх, Др.Арунаселам Расаппан (Ph.D.)

Логик уялдааны загварыг дараах 2 багц шинжилгээнд үндэслэн тодорхойлдог. Үүнд:

Зураг 5. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хүрээнд хийх багц шинжилгээ буюу үе шат



Эрэлтийн буюу нөхцөл байдлын дүн шинжилгээ нь оролцогч талын шинжилгээ, хэрэгцээ ба асуудлын шинжилгээнээс бүрдэнэ. Энэхүү шинжилгээнд үндэслэн үр дүнгийн шинжилгээг хийх ба үр дүнгийн шинжилгээ нь бодлогын орц, үйл ажиллагаа, гарц, төлөвлөсөн үр дүн гэсэн бүрдэл хэсэгтэй.

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хүрээнд хийх логик уялдааны загвар нь төлөвлөлтийн дээрээс доош чиглэсэн аргад үндэслэдэг ба ерөнхийгөөс нарийвчилсан

үр дүн рүү чиглүүлж нэгдмэл, цогц, харилцан уялдаатай боловсруулалт, төлөвлөлт хийхийг зорьдог.

Төлөвлөлтийн дээрээс доош чиглэсэн арга нь урт хугацаанд, улс орны хэмжээнд хүлээгдэж буй ерөнхий үр дүн буюу ерөнхий хэрэгцээ, асуудлыг тодорхойлж түүнийг нарийвчлах ба энэ нь хүн, нийгэм, эдийн засаг, байгаль орчин засаглал гэсэн үндсэн 5 хүрээгээр багцлагдах боломжтой байдаг.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид үндэслэн авч үзвэл улс орны хэмжээнд хүлээгдэж буй ерөнхий хэрэгцээ, асуудлыг салбараар, төсвийн ерөнхийлөн захирагчийн (ТЕЗ) эрхлэх асуудлын хүрээгээр, төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрөөр гэсэн дарааллаар нарийвчлах боломжтой байна.

Иймд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд үр дүнг дараах 4 түвшинд тодорхойлохыг санал болгож байна. Үүнд:

- Үндэсний түвшин
- Салбарын түвшин
- ТЕЗ-ийн эрхлэх асуудлын түвшин (цаашид ТЕЗ-ийн түвшин гэх)
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн түвшин (цаашид Хөтөлбөрийн түвшин гэх)

Энэхүү 4 түвшинг хамарсан логик уялдааны загварыг боловсруулахдаа дараах арга зүйг ашиглах боломжтой. Үүнд:

- Үндэсний түвшинд тулгарч буй ерөнхий хэрэгцээ, асуудал болон түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, сонгосон арга замтай уялдуулан асуудлын шалтгааныг салбараар ангилан тодорхойлох. Өөрөөр хэлбэл үндэсний түвшинд тулгарч буй ерөнхий хэрэгцээ, асуудлын шалтгаан нь Салбарын түвшинд тулгарч буй үндсэн хэрэгцээ, асуудал болно.


- Салбарын түвшинд тулгарч буй үндсэн хэрэгцээ, асуудал болон түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, сонгосон арга замтай уялдуулан асуудлын шалтгааныг ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээгээр нарийвчлан ангилан тодорхойлох. Өөрөөр хэлбэл салбарын түвшинд тулгарч буй үндсэн хэрэгцээ, асуудлын шалтгаан нь ТЕЗ-ийн түвшинд тулгарч буй үндсэн хэрэгцээ, асуудал болно.

- ТЕЗ-ийн түвшинд тулгарч буй үндсэн хэрэгцээ, асуудал болон түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, сонгосон арга замтай уялдуулан асуудлын шалтгааныг ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээгээр нарийвчлан ангилан тодорхойлох. Өөрөөр хэлбэл ТЕЗ-ийн түвшинд тулгарч буй үндсэн хэрэгцээ, асуудлын шалтгаан нь ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн түвшинд шийдвэрлэх хэрэгцээ, асуудал болно.

- Дээрх шалтгаан, үр дагавраар холбогдсон хэрэгцээ, асуудлыг шийдвэрлэхийн тулд төрийн холбогдох байгууллагуудаас нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ (гарц) болон үйл ажиллагаа, орцыг тодорхойлох

Энэхүү арга зүйг дараах зураглалаар илэрхийлэв.

Зураг 6. ҮДСНУ-ын хүрээнд санал болгож буй бодлого боловсруулалт, төлөвлөлтийн аргачлал



Эх сурвалж: Сургалтын материал, НҮБХХ-ийн төслийн зөвлөх, Др.Арунаселам Расаппан (Ph.D.)

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

• **Хөгжлийн бодлогын баримт бичиг**

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /30 жил/
- Хөгжлийн зорилтот хөтөлбөр /10 жил/

• **Хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг**

- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /5 жил, үндэсний түвшин/
- Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /5 жил, орон нутгийн түвшин/
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /4 жил, үндэсний түвшин/
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /4 жил, орон нутгийн түвшин/
- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв /1 жил/

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Логик уялдааны загварыг уялдуулан авч үзвэл

- Хөгжлийн бодлогын баримт бичиг буюу урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах хүрээнд үндэсний болон салбарын түвшинд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, үндэсний болон салбарын үр дүнг тус баримт бичигт тусгах
- Хөгжлийн бодлогын баримт бичигт үндэслэн дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах хүрээнд ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний болон ТЕЗ-ийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийн түвшинд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүнг тус баримт бичигт тусгах боломжтой байна.

Өөрөөр хэлбэл хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үр дүнг дараах байдлаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг тусгах боломжтой. Үүнд:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого
 - о Үндэсний үр дүн /30 жил/ - Бодлогын зорилго /30 жилээр төлөвлөх/
 - о Салбарын үр дүн /30 жил/ - Салбарын зорилт /30 жилээр төлөвлөх/
- Хөгжлийн зорилтот хөтөлбөр
 - о Үндэсний үр дүн /10 жил/ - Бодлогын зорилго /10 жилээр төлөвлөх/
 - о Салбарын үр дүн /10 жил/ - Салбарын зорилт /10 жилээр төлөвлөх/
- Таван жилийн үндсэн чиглэл
 - о Үндэсний үр дүн /5 жил/ - Бодлогын зорилго /5 жилээр төлөвлөх/
 - о Салбарын үр дүн /5 жил/ - Салбарын зорилт /5 жилээр төлөвлөх/
 - о ТЕЗ-ийн үр дүн /5 жил/ - ТЕЗ-ийн зорилт /5 жилээр төлөвлөх/
 - о Хөтөлбөрийн үр дүн /5 жил/ - Хөтөлбөрийн зорилт /5 жилээр төлөвлөх/
- Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
 - о Салбарын үр дүн /4 жил/ - Салбарын зорилт /4 жилээр төлөвлөх/
 - о ТЕЗ-ийн үр дүн /4 жил/ - ТЕЗ-ийн зорилт /4 жилээр төлөвлөх/
 - о Хөтөлбөрийн үр дүн /4 жил/ - Хөтөлбөрийн зорилт /4 жилээр төлөвлөх/
 - о Хөтөлбөрийн гарц /4 жил/
- Улс болон аймаг, нийслэлийн жилийн хөгжлийн төлөвлөгөө
 - о Салбарын үр дүн /1 жил/ - Салбарын зорилт /1 жилээр төлөвлөх/
 - о ТЕЗ-ийн үр дүн /1 жил/ - ТЕЗ-ийн зорилт /1 жилээр төлөвлөх/
 - о Хөтөлбөрийн үр дүн /1 жил/ - Хөтөлбөрийн зорилт /1 жилээр төлөвлөх/
 - о Хөтөлбөрийн гарц /1 жил/

Дээрх баримт бичгүүдийг боловсруулж, батлахдаа олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалтыг харгалзан үзэж тусгах нь оновчтой. Өөрөөр хэлбэл олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалтыг тусад нь баримт бичиг боловсруулж, батлах байдлаар бус үүрэг, амлалтын хүрээнд хүлээгдэж буй үр дүн, шалгуур үзүүлэлтийг дээрх баримт бичигтээ тусгах нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

Жишээлбэл, Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтууд нь хугацааны хувьд Монгол Улсын урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, дунд хугацааны буюу 10 жилийн “Хөгжлийн зорилтот хөтөлбөр”-т тусгагдах нь таарамжтай боловч 17 зорилго, 169 зорилт, тэдгээрийн 244 шалгуур үзүүлэлтүүдийн хувьд 4 түвшний (үндэсний, салбарын, ТЕЗ, хөтөлбөрийн) үр дүнд тохирох байдлаар ангилан, хамаарах бодлогын баримт бичгүүдэд тусгах нь оновчтой юм. Учир нь ТХЗ-ууд болон тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд нь энэхүү аргачлалд заасан 4 түвшний үр дүнгийн аль нэг түвшинд бүгд шууд хамаарагдах байдлаар тодорхойлогдоогүй юм.

3 НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт нь бодлого, төлөвлөлтийн хүрээнд шийдвэрлэх хэрэгцээ, асуудлыг тодорхойлох буюу нөхцөл байдлыг оношлохоос эхэлдэг.

Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь

- Нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүний хөгжил, засаглалын өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн таамаглал;
- Дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг амлалт болон түүний хэрэгжилт. Тухайлбал, “Тогтвортой хөгжлийн зорилго”, “Парисын хэлэлцээр” гэх мэт;
- Өмнө хэрэгжүүлсэн Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ зэргийг хамарна.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн гэсэн 4 түвшинд авч үзэх талаар өмнөх хэсэгт хөндөж авч үзсэн. Иймд нөхцөл байдлын дүн шинжилгээг мөн энэхүү 4 түвшинд уялдуулан хийнэ.

Нөхцөл байдлын дүн шинжилгээг дараах алхмын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Алхам 1.** Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээг тодорхойлох
- Алхам 2.** Оролцогч талын шинжилгээ болон үр шим хүртэгч ба зорилтот бүлгийг тодорхойлох
- Алхам 3.** Хэрэгцээ, асуудлыг тодорхойлох
- Алхам 4.** Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратеги/-ыг тодорхойлох
- Алхам 5.** Асуудлыг хэмжих үзүүлэлт, асуудлын хамрах хүрээ, тархалтын хурдыг тодорхойлох
- Алхам 6.** Оролцогч талын шинжилгээнд үндэслэн хэрэгцээ, асуудлын үндсэн ба хамтран хариуцагчийг тодорхойлох

Нөхцөл байдлын дүн шинжилгээг хийхдээ дараах ажлын хүснэгтийг ашиглах боломжтой. Үүнд:

Хүснэгт 1. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ажлын хүснэгт

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратеги/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
Үндэсний хэрэгцээ, асуудал						
						Салбар 1
						Салбар 2
Салбарын хэрэгцээ, асуудал						
						ТЕЗ 1
						ТЕЗ 2
ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудал						
						Хөтөлбөр 1
						Хөтөлбөр 2
Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ, асуудал						
						Байгууллага 1
						Байгууллага 2

Алхам 1. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээг тодорхойлох нь

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийг системтэй, давхцал, хийдэлгүй төлөвлөх арга зүйн хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх эхний алхам нь “Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ”-г тодорхойлох явдал байдаг. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ нь дүн шинжилгээг чиглүүлж, хязгаарлахаас гадна давхцал, хийдлийг арилгах гол хэрэгсэл болдог.

Үндэсний түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ:

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт нь дээрээс доош буюу ерөнхийгөөс нарийвчилсан асуудал руу чиглүүлэх ерөнхий арга зүйд суурилдаг. Иймд нөхцөл байдлын дүн шинжилгээ мөн адил зарчмаар хийгдэнэ. Үндэсний түвшинд улс орны хөгжлийн ерөнхий хэрэгцээ, асуудлыг тодорхойлохын тулд Улс орны хөгжлийг хүн, нийгэм, байгаль орчин, засаглал, эдийн засаг гэсэн үндсэн хүрээгээр болон энэхүү ерөнхий хүрээгээ илүү нарийвчлан тодорхой хүрээг тодорхойлж шинжлэх боломжтой. Үндэсний түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээний жишээг (“эдийн засаг” гэсэн үндсэн хүрээг нарийвчлан “эдийн засгийн өгөөж” гэсэн нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээг тодорхойлсон) дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2. Үндэсний түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээний жишээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратегии/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
Үндэсний хэрэгцээ, асуудал						
Эдийн засгийн өгөөж						

Салбарын түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ:

Салбарын түвшинд тулгамдсан үндсэн хэрэгцээ, асуудлыг тодорхойлохын тулд Үндэсний хэрэгцээ, асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах салбаруудыг тодорхойлж салбарын түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээг тодорхойлох боломжтой.

“Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд засгийн газрын чиг үүргийн ангилал (COFOG) болон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны стандарт ангилал (ISIC) дээр түшиглэн Монгол Улсын хувьд дараах 21 салбар байх боломжтой хэмээн тодорхойлсон. Эдгээр салбарын жагсаалт болон салбарын тодорхойлолтыг хавсралт 1-д тусгав.

Салбарын ангиллыг НҮБ-ын статистикийн газар¹ болон Эдийн засгийн хамтын

¹/United Nations Statistical Division/
²/Organization for Economic Co-operation and Development/
³ /The Classification of the Functions of Government (COFOG)/
⁴ /The International Standard Industrial Classification of All Economic Activities (ISIC)/

ажиллагааны байгууллага²-аас хэвлүүлсэн Засгийн газрын чиг үүргийн ангилал³-ыг үндэслэн Монгол Улсын хөгжлийн онцлог, төрийн гүйцэтгэх чиг үүргийн өнөөгийн нөхцөл байдал болон Эдийн засгийн бүх үйл ажиллагааны олон улсын үйлдвэрлэлтийн стандартын ангилал⁴-тай харьцуулан боловсруулсан. Манай улсын Засгийн газрын чиг үүргийн ангилал нь олон улсын ангилалтай ерөнхий зүй тогтлын хувьд дүйж байгаа хэдий ч эдийн засгийн үйл хэргийн дэд ангиллын чиг үүрэг буюу дэд салбарыг энд үндсэн салбарын ангилал болгон оруулав. Салбарын нэрийн дараагийн баганад олон улсын хоёр ангиллыг харгалзах агуулгаар оруулан харууллаа.

Хүснэгт 3. Салбарын ангиллын харьцуулалт ба санал болгож буй салбарын жагсаалт

№	Салбарын ангилал	The Classification of the Functions of Government (COFOG)	The International Standard Industrial Classification of All Economic Activities (ISIC)
1	Төрийн удирдлага	01 - General public services	O Public administration and defence; compulsory social security
2	Гадаад харилцаа		
3	Батлан хамгаалах		
4	Хууль, дотоод хэрэг		
5	Санхүү	04.1 - General economic, commercial, and labour affairs	
	Хөдөлмөр эрхлэлт		
6	Хөдөө аж ахуй	04.2 - Agriculture, forestry, fishing and hunting	A Agriculture, forestry and fishing
7	Эрчим хүч	04.3 - Fuel and energy	D Electricity, gas, steam, and air conditioning supply CD Manufacture of coke and refined petroleum products
8	Уул уурхай	04.4 - Mining, manufacturing and construction	B Mining and quarrying
9	Боловсруулах үйлдвэрлэл		CA---- CM Other manufacturing
10	Барилга ⁶		F Construction
	Барилга ⁷	06 - Housing and community amenities	
11	Зам, тээвэр	04.5 - Transport	H Transportation and storage
12	Мэдээлэл, харилцаа холбоо	04.6 - Communication	JB Telecommunications JC IT and other information services
13	Хүнс	04.7 - Other industries	I Accommodation and food service activities
14	Аялал жуулчлал		
15	Худалдаа		G Wholesale and retail trade;
16	Үйлчилгээний бусад		S Other service activities
17	Байгаль орчны хамгаалал	05 - Environmental protection	
18	Эрүүл мэнд	07- Health	QA Human health activities
19	Соёл	08 - Recreation, culture and religion	R Arts, entertainment, and recreation
20	Боловсрол	09 - Education	P Education
21	Нийгмийн хамгаалал	10 - Social protection	QB Residential care and social work activities

⁵ Энэ economic affairs- эдийн засгийн үйл хэрэг гэдгийг нэлээд задалсан байна.

⁶ Үүнийг Их барилга гээд ерөнхийдөө бол бизнес буюу ажил хэргийн зориулалттай барилга

⁷ Орон сууц гээд ахуйн зориулттай байр орон сууц, орчны тав тух гэсэн агуулгаар салбар гаргаж болно.

Хүснэгт 4. Салбарын түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээний жишээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратегии/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
Салбарын хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөр эрхлэлт (Бүх салбар)						

ТЕЗ-ийн түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ:

Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон Төрийн байгуулал (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал) буюу төрийн чиг үүргийг холбогдох хууль тогтоомжоор ТЕЗ-дад нарийвчлан ангилж хуваарилдаг. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайдын эрхлэх асуудлын хүрээг тодорхойлж өгсөн байдаг.

ТЕЗ-ийн түвшинд тулгамдсан үндсэн хэрэгцээ, асуудлыг тодорхойлохын тулд Салбарын хэрэгцээ, асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах тухайн салбарыг хариуцсан ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээг ТЕЗ-ийн түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ болгон сонгох боломжтой.

Хүснэгт 5. ТЕЗ-ийн түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээний жишээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратегии/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт (ХНХС)						

Хөтөлбөрийн түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ:

ТЕЗ нь эрхлэх асуудлын хүрээнд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ чиг үүргийг тодорхой хөтөлбөрүүдэд ангилан гүйцэтгэдэг.

“Хөтөлбөр”-ийн талаарх ойлголт нь улс орон бүрд ижил байдаг боловч түүний тодорхойлолт, нэр томъёолол нь тухай улсын удирдлагын тогтолцоо, төсвийн системийн онцлогоос шалтгаалан ялгаатай байдаг.

Хөтөлбөр нь зарим талаар яам, агентлаг зэрэг захиргааны бүтэцтэй андуурагддаг. Хөтөлбөр нь яам, агентлагийн бүтэцтэй таарч болох боловч хөтөлбөрийг тодорхойлох үйл явц нь улс орны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй нягт уялдаатай байх шаардлагатай байдаг. Энэ утгаараа Засгийн газрын бүтэц нь улсын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө дээр үндэслэгдэж, түүнд чиглэсэн хөтөлбөрийг тодорхойлох нь

бодлогыг төсөвтэй уялдуулж хамгийн үр дүнтэй, үр ашигтай байдлаар зорилтот үр дүндээ хүрэх ач холбогдолтой байдаг.

Монгол Улсын хувьд Төсвийн тухай хуулийн 4.1.16-д “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг” гэж тодорхойлсон байдаг. Харин үр дүнд суурилсан удирдлагын тогтолцооны хүрээнд хөтөлбөрийг “Тодорхой хугацаанд, зорилтод өөрчлөлтийг илэрхийлсэн нэг буюу хэд хэдэн үр дүнг бий болгохоор зорьж буй хэд хэдэн багц арга хэмжээ буюу гарцыг хэлнэ”⁸ гэж тодорхойлсон байдаг.

Мөн Дэлхийн Банкнаас 2013 онд гаргасан “Гүйцэтгэлд суурилсан төсвийн ангилал: Нотолгоонд суурилсан төсвийн бүтэц” товхимолд “Үр дүнд суурилсан хөтөлбөр гэж нэг үр дүнд хүрэх зорилготой, эсвэл нэгдмэл зорилтод бүлэгт чиглэсэн төрөл бүрийн гарцын багц/төлбөрийн шилжүүлгийг хэлнэ”⁹ гэж Марк Робинсон тодорхойлсон байна.

Үр дүнг тодорхойлох үйл явц нь шалтгаан-үр дагаврын цогц шинжилгээ дээр үндэслэгдэх бөгөөд үр дүнд суурилсан хөтөлбөрийг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудыг хангахад чиглэгдсэн уялдаа холбоо бүхий нэгдсэн үр дүнгийн хүрээг үндэслэн тодорхойлно.

Үр дүнд суурилсан хөтөлбөрийн үндсэн зорилго нь орцыг ашиглан гарцыг бий болгож зорилтод үр дүнд хүрэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино¹⁰.

Хөтөлбөрийг ерөнхийд нь хэрэгцээнд суурилсан эсвэл асуудалд суурилсан гэж ангилдаг. Асуудалд суурилсан хөтөлбөр нь тухайн асуудал шийдвэрлэгдсэнээр дуусгавар болдог бол хэрэгцээнд суурилсан хөтөлбөр нь байнгын давтагдах шинжтэй чанартай байдаг. Үр дүнд суурилсан хөтөлбөр нь дээрх хоёр хөтөлбөрийн аль нь ч байж болно.

Үр дүнд суурилсан хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хөтөлбөр нь үр дүнгийн логик, гинжин холбоо буюу үр дүнгийн хүрээнд үндэслэгдэн тодорхойлогдсон байх;
2. Хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх асуудал, шалтгаан, хэрэгцээ тодорхой байх;
3. Хөтөлбөрийн үр шим хүртэгчид, хүн амын зорилтод бүлэг тодорхой байх;
4. Хөтөлбөрийн үр дүн, үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, хугацаа тодорхой байх;
5. Хөтөлбөр нь зорилтод үр дүнг хангах гарцтай байх;
6. Хөтөлбөр нь гарцыг бий болгох арга хэмжээтэй байх;
7. Хөтөлбөр нь хэрэгжих хугацаатай байх;
8. Хөтөлбөр нь арга хэмжээг хэрэгжүүлэх орц буюу санхүүгийн болон санхүүгийн бус нөөцтэй байна.

⁸Glossary of Terms IRBM System Version 7.5 Oct 2020 (I)

⁹Program-classification-for-performance-based-budgeting-how-to-structure-budgets-to-enable-the-use-of-evidence_Marc Robinson WB, page 7.

¹⁰Program-classification-for-performance-based-budgeting-how-to-structure-budgets-to-enable-the-use-of-evidence_Marc Robinson WB, page 8

Хөтөлбөр тодорхойлж буй олон улсын практикт хөтөлбөрийг хоёр янзаар тодорхойлдог.

- 1. Төрийн үндсэн чиг үүрэг буюу ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд үндэслэн ерөнхийгөөр тодорхойлох,
- 2. ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээг нарийвчлан задалж, түүнд үндэслэн нарийвчилсан байдлаар тодорхойлох,

Хөтөлбөрийг хэт ерөнхий байдлаар тодорхойлох нь тухайлсан тодорхой асуудал орхигдох сул талтай байдаг бол хөтөлбөрийг хэт нарийвчилсан байдлаар тодорхойлох нь хөтөлбөрүүдийн хооронд гарц, үйл ажиллагаа, арга хэмжээний давхцал үүсэх сул талтай байдаг. Иймд хөтөлбөрийг хэт ерөнхийлөх болон хэт нарийвчлахаас зайлсхийж дундын хувилбарыг гаргаж ирэхийг улс орнууд зорьдог бөгөөд хамгийн гол нь хөтөлбөрийн зорилго, зориулалтыг тодорхой бөгөөд ойлгомжтой байдлаар тодорхойлоход анхаарах шаардлагатай.

Хөтөлбөрийн түвшинд тулгамдсан үндсэн хэрэгцээ, асуудлыг тодорхойлохын тулд ТЕЗ-ийн түвшинд тулгамдаж буй хэрэгцээ, асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийг тодорхойлж (ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээг нарийвчлан) хөтөлбөрийн түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ болгон сонгох боломжтой.

Хүснэгт 6. Хөтөлбөрийн түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээний жишээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратегии/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа (ТЕЗ-ийн бодлого, удирдлага хөтөлбөр)						

Нөхцөл байдлын дүн шинжилгээг хийхдээ Үндэсний түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээг хийсний дараагаар Салбарын түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээг хийх гэсэн дарааллаар явагдана. Өөрөөр хэлбэл үндэсний түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээг тодорхойлсны дараагаар шууд салбарын түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээг тодорхойлно гэж ойлгож болохгүй. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ хоорондын уялдааг дараах зургаар илэрхийлэв.

Зураг 7. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ хоорондын уялдаа

Үндэсний түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ

Хүний хөгжил	Нийгмийн хөгжил	Эдийн засгийн хөгжил	Байгаль орчин	Засаглалын хөгжил
--------------	-----------------	----------------------	---------------	-------------------

Салбарын түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ

Эрүүл мэндийн салбар	Боловсролын салбар	ХАА-н салбар		Төрийн удирдлагын салбар
----------------------	--------------------	--------------	------	--------------------------

ТЕЗ-ийн түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээ №1	ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээ №2	ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээ №3	ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээ №....	ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээ №.N
----------------------------------	----------------------------------	----------------------------------	-------------------------------------	-----------------------------------

Хөтөлбөрийн түвшинд хийх нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээ

ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр №1	ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр №2	ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр №3	ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр №....	ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр №.N
---------------------------------	---------------------------------	---------------------------------	------------------------------------	----------------------------------

Алхам 2. Оролцогч талын шинжилгээ болон үр шим хүртэгч ба зорилтот бүлгийг тодорхойлох нь

Нөхцөл байдлын дүн шинжилгээний 2 дахь алхам нь “Оролцогч талын шинжилгээ болон үр шим хүртэгч ба зорилтот бүлэг”-г тодорхойлох явдал байдаг. Энэ нь нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлох хэрэгцээ, асуудлыг оновчтой, системтэй тодорхойлох урьдач нөхцөл болж өгдөг.

Оролцогч талын шинжилгээг мөнд адил 4 түвшинд хийх ба

1. Үндэсний түвшинд оролцогч тал нь нийт иргэд, төр засаг
2. Салбарын түвшинд оролцогч тал нь салбарууд
3. ТЕЗ-ийн түвшинд оролцогч тал нь ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ижил шинж чанараараа нэгдсэн нийгмийн бүлгүүд
4. Хөтөлбөрийн түвшинд оролцогч тал нь хөтөлбөрийн хүрээнд хамаарах ижил шинж чанараараа нэгдсэн нийгмийн дэд бүлгүүд болно.

ШИГТГЭЭ 1.

ОРОЛЦОГЧ ТАЛЫН ШИНЖИЛГЭЭ

Асуудалд хамаарал бүхий талыг ерөнхийд нь үйлчлүүлэгч (зорилтот бүлэг) тал, үр шим хүртэгч тал, хохирол хүлээх тал, сонирхогч тал, үйлчилгээ үзүүлэгч тал хэмээн ангилж болно.



Үйлчлүүлэгч (зорилтот бүлэг) тал гэдэг нь тухайн асуудлыг үүсгэж буй нийгмийн үндсэн бүлэг юм. Энэ бүлэгт чиглэсэн бодлого, шийдвэр гаргах шаардлагатай гэдэг утгаар нь үйлчлүүлэгч тал гэж тодорхойлсон болно.

Үр шим хүртэгч тал гэдэг нь асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд бодлогын үр шимийг хүртэх нийгмийн бүлэг юм. Асуудлын онцлогоос шалтгаалан зарим тохиолдолд зорилтот бүлэг болон үр шим хүртэгч тал нь нэг байж болно.

Хохирол хүлээх тал гэдэг нь тухайн асуудал, харилцаанаас болж алдагдал хүлээж буй нийгмийн бүлэг юм.

Сонирхогч тал гэдэг нь тухайн асуудлаас ямар нэг байдлаар ашиг, алдагдал хүлээхгүй боловч тухайн асуудал, харилцааг сонирхож буй нийгмийн бүлэг юм. Зарим асуудлын онцлог байдлаас шалтгаалан хохирол хүлээх тал нэгдэн нийлж сонирхогч талыг үүсгэж болно.

Үйлчилгээ үзүүлэгч тал гэдэг нь тухайн асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг хүлээсэн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч буюу төрийн холбогдох байгууллага, албан хаагчид болон орлох бүтээгдэхүүнийг нийлүүлэгчид юм.

Хэрэгцээ, асуудлын онцлогоос шалтгаалан үр шим хүртэгч ба зорилтот бүлэг нь нэг байх эсвэл ялгаатай байх боломжтой.

Дараах хэсэгт нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд үр шим хүртэгч ба зорилтот бүлгийг тодорхойлсон жишээг оруулав. Үүнд:

Хүснэгт 7. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд үр шим хүртэгч ба зорилтот бүлгийг тодорхойлсон жишээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратегий/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
Үндэсний хэрэгцээ, асуудал						
Эдийн засгийн өгөөж	Нийт иргэд					
Салбарын хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөр эрхлэлт (Бүх салбар)	Хөдөлмөрийн насны хүн ам					
ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт (ХНХС)	Ажил олгогч ба ажиллах хүч					
Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа (ТЕЗ-ийн бодлого, удирдлага хөтөлбөр)	Судалгааны хэрэгцээ бүх талууд					

АНХААРАХ ЗҮЙЛ:

Үндэсний түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээг хийсний дараагаар Салбарын түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээг хийх гэсэн дарааллаар явагдана.

Оролцогч талын шинжилгээний хүрээнд хэрэгцээ, асуудалд хамаарал бүхий талуудыг тодорхойлохдоо

- 1. **Салбарын түвшинд** нийт салбарын жагсаалтаас тухайн хэрэгцээ, асуудалд шууд нөлөөлөх салбаруудыг сонгох
- 2. **ТЕЗ-ийн түвшинд** нийт ТЕЗ-ийн жагсаалтаас тухайн хэрэгцээ, асуудалд шууд нөлөөлөх ТЕЗ-ийг сонгох
- 3. **Хөтөлбөрийн түвшинд** нийт хөтөлбөрийн жагсаалтаас тухайн хэрэгцээ, асуудалд шууд нөлөөлөх хөтөлбөрийг сонгож тэдгээрт хамаарах үр шим хүртэгч ба зорилтот бүлгийг тодорхойлно.

ШИГТГЭЭ 2.

ОРОЛЦОГЧ ТАЛЫН ШИНЖИЛГЭЭ

УИХ-аас 2011 онд баталсан Төсвийн тухай хуулийн 14.1-ийн хүрээнд 2024 оны 03 сарын 01-ны байдлаар нийт 39 Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ) үйл ажиллагаа явуулж байна.

УИХ-аас жил бүр баталж буй Монгол Улсын жилийн төсвийн 1 дүгээр хавсралтын хүрээнд ТЕЗ-ийн хэрэгжүүлж буй нийт 92 хөтөлбөр байна.

Алхам 3. Хэрэгцээ, асуудлыг тодорхойлох нь

Нөхцөл байдлын дүн шинжилгээний 3 дахь алхам нь “Хэрэгцээ, асуудал”-г тодорхойлох явдал байдаг. Жишээлбэл, Улс орнуудын өмнө тулгарч буй нийтлэг хэрэгцээ, шаардлагыг “Тогтвортой хөгжлийн зорилго”-д ядуурал; өлсгөлөн; хүн амын эрүүл мэнд; боловсролын чанар; баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламж; жендэрийн эрх, тэгш байдал; тэгш бус байдал; хариуцлагатай хэрэглээ; энх тайван, шударга ёс; иргэдийн оролцоо; хөгжлийн төлөөх түншлэл, хамтын ажиллагаа; зохистой хөдөлмөр эрхлэлт, баталгаат ажлын байр; уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчин, эко системийн тэнцвэртэй байдал хэмээн тодорхойлсон байна.

Хэрэгцээ, асуудлыг тодорхойлохдоо үр шим хүртэгч ба зорилтот бүлэгт ямар хэрэгцээ, асуудал байна вэ? гэсэн асуултын хүрээнд хийгдэнэ.

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хүрээнд төрийн бодлогын асуудлыг үндэсний түвшинд тулгамдсан хэрэгцээ/асуудал, салбарын түвшинд тулгамдсан хэрэгцээ/асуудал, салбарын тодорхой нэг чиглэлийн хүрээнд тулгамдсан хэрэгцээ/асуудал гэх мэтээр түвшнээр нь ялгаж харах шаардлага үүсдэг.

“Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд Монгол Улсад ҮДСНУ-ын арга зүйг нутагшуулахад тулгарсан нэг гол асуудал нь үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн түвшинд тулгамдсан асуудлыг бие биеэс нь хэрхэн ялгаж оролцогч талуудыг нэгдмэл ойлголттой болгох вэ? гэсэн асуулт байсан.

Энэхүү асуултад хариулах зорилгоор дараах тодорхойлолтыг санал болгож байна. Үүнд:

- “Үндэсний түвшний хэрэгцээ/асуудал” гэж улс оршин байх тулгуур үзүүлэлтэд шууд нөлөөлөх ерөнхий хэрэгцээ/асуудал;
- “Салбарын түвшний хэрэгцээ/асуудал” гэж үндэсний хэрэгцээ/асуудалд шууд нөлөөлөх тухайн салбарын үндсэн хэрэгцээ/асуудал;
- “Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшний хэрэгцээ/асуудал” гэж салбарын хэрэгцээ/асуудалд шууд нөлөөлөх төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нийгмийн бүлгүүдийн хэрэгцээ/асуудал;
- “Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ/асуудал” гэж төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгцээ/асуудалд шууд нөлөөлөх ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нийгмийн бүлгүүдийн хэрэгцээ/асуудлыг сэдэлжүүлж буй орчин (дотоод, гадаад) нөхцөл;

Дээрх тодорхойлолтод үндэслэн үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн түвшинд тулгамдсан хэрэгцээ, асуудлыг оновчтой тодорхойлсон эсэхийг нягтлах хяналтын хуудсыг хавсралт 2-т тусгав.

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хүрээнд асуудлуудыг түвшнээр ялгах энэхүү аргачлал нь дараах дарааллын дагуу хийгдэхээр боловсруулагдсан болно. Үүнд:

- Иргэд, улс орны хэмжээнд хүлээгдэж буй үндсэн хэрэгцээ/асуудал (ерөнхий үр дүн) юу вэ?
- Дээрх хэрэгцээ/асуудлыг (ерөнхий үр дүн) хангагдахын тулд салбаруудын ямар үндсэн хэрэгцээ/асуудал (салбаруудын оруулах үндсэн үр дүн) хангагдсан байх шаардлагатай вэ?
- Салбарын үндсэн хэрэгцээ/асуудал (салбарын үр дүн) салбарын асуудлыг үүсгэж буй зорилтот бүлгийн ямар буруу зан төлөв, үйлдлээс (зөв зан төлөв, үйлдэл) хамаарч бий болж байна вэ?
- Салбарын асуудлыг үүсгэж буй зорилтот бүлгийн буруу зан төлөв, үйлдлийг сэдэлжүүлж буй үндсэн шалтгаан нь (дотоод -мэдлэг, ойлголт болон гадаад -улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, байгаль орчин, технологи, хууль эрх зүйн орчин нөхцөл-шалтгаан) юу байна вэ?

Дараах хэсэгт нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд хэрэгцээ, асуудлыг тодорхойлсон жишээг оруулав. Үүнд:

Хүснэгт 8. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд хэрэгцээ, асуудал тодорхойлсон жишээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратеги/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
Үндэсний хэрэгцээ, асуудал						
Эдийн засгийн өгөөж	Нийт иргэд	Ядуурал түвшин өндөр, дундаж давхаргын хүрээ бага, ядууралд өртөх эрсдэл өндөр байна				
Салбарын хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөр эрхлэлт (Бүх салбар)	Хөдөлмөрийн насны хүн ам	Хөдөлмөр эрхлэлт бага байна				
ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт (ХНХС)	Ажил олгогч ба ажиллах хүч	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдсан				
Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа (ТЕЗ-ийн бодлого, удирдлага хөтөлбөр)	Судалгааны хэрэгцээ бүх талууд	Хөдөлмөрийн зах зээлийн урт, дунд, богино хугацааны эрэлтийг оновчтой таамаглаж чадахгүй байна				

АНХААРАХ ЗҮЙЛ:

Үндэсний түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээг хийсний дараагаар Салбарын түвшний нөхцөл байдлын дүн шинжилгээг хийх гэсэн дарааллаар явагдана.

Төрийн бодлого, шийдвэр нь нийгмийн харилцааг зохицуулах, иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн амьдралын чанар, сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэдэг. Иймд нөхцөл байдлын дүн шинжилгээ нь энэ хүрээнд хэрэгцээ, асуудлыг тодорхойлно.

ШИГТГЭЭ 3.

ХЭРЭГЦЭЭ БА АСУУДАЛ

Хэрэгцээ гэдэг нь амьд бие, бие хүн, нийгмийн бүлэг, бүхэл нийгэм, улс, үндэстний оршин амьдрахад зайлшгүй ямар нэгэн юмыг шаардах шаардлага буюу оршихуйн үндэс юм. Харин асуудал гэдэг нь хангагдаагүй хэрэгцээ, хэрэгжээгүй шаардлага буюу хэрэгцээнд үүссэн гажилт, доголдлыг хэлнэ.

Жишээлбэл, эхийн хэвлийгээс унасан хүмүүнд эрүүл саруул байж урт хугацаанд амьдрах, сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинд амьдрах гэх мэт олон төрлийн хэрэгцээ үүсдэг. Энэхүү хэрэгцээ хангагдаагүйгээс өвчлөл, нас баралт, хүмүүжил, ёс суртахууны доройтол, агаарын бохирдол, хөрсний бохирдол гэх мэт олон төрлийн асуудал үүсдэг.

Хэрэгцээ, асуудлыг уялдуулан авч үзвэл төрийн бодлогын хүрээнд хэрэгцээг танин мэдэж чадвал, асуудлыг урьдчилан харах боломжийг олгоно.

Хөгжлийн бодлогын хүрээнд тодорхойлох хэрэгцээ, асуудал нь хүн, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалын өргөн хүрээг хамардаг учир эдгээр хүрээнд үүссэн хэрэгцээ, асуудал нь хоорондоо сүлжилдэж, нэг нэгэндээ нөлөөлж байдаг. Өөрөөр хэлбэл тухайн нэг асуудал нь өөр нэг асуудлын шалтгаан, өөр нэг асуудлын үр дагавар болж байдаг.

Иймд төрийн бодлого боловсруулалт, төлөвлөлтийн хүрээнд дан ганц асуудлыг бус асуудлын шалтгаан, үр дагаврын харилцан хамаарлыг танин мэдэх шаардлагатай тулгардаг.

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт нь дээрээс доош аргад суурилан, логик уялдааны загварт үндэслэж, шалтгаант холбоог гаргах арга зүйд суурилдаг. 4 түвшинд тодорхойлсон хэрэгцээ, асуудлыг тус тусад нь авч үзвэл салангид асуудал болох боловч хооронд нь уялдуулан авч үзвэл нэг асуудал нь нөгөө асуудлын шалтгаан, өөр нэг асуудлын үр дагавар болдог.

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон

- Хөтөлбөрийн хэрэгцээ, асуудлын үр дагавар нь ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудал
- ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудлын үр дагавар нь Салбарын хэрэгцээ, асуудал
- Салбарын хэрэгцээ, асуудлын үр дагавар нь Үндэсний хэрэгцээ, асуудал болно.

ШИГТГЭЭ 4.

АСУУДЛААС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР:

Үр дагавар гэдэг нь тулгамдсан асуудлын шууд нөлөөгөөр хүний хөгжил, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалын хүрээнд үүссэн үзэгдэл, үйл явцыг хэлнэ.

Асуудлын үр дагаврыг тодорхойлох үндсэн арга, аргачлал нь “асуудал”, “үр дагавар” хэмээн тодорхойлж буй үзэгдэл, үйл явцуудын хооронд шууд хамаарал байгаа эсэхийг тодорхойлох явдал юм. Үр дагавар нь цаг хугацааны хувьд асуудлын дараа үүснэ. Асуудал, үр дагавар хоорондын шууд хамаарлыг баримт, нотолгоонд үндэслэн тодорхойлно.

Үр дагавар нь харьцангуй цогц шинжтэй, хэд хэдэн асуудлын шууд нөлөөгөөр үүсдэг үзэгдэл, үйл явц юм. Иймд асуудлын үр дагаврыг тодорхойлохдоо бусад асуудлаас үүсэж буй адил төстэй үр дагавруудыг нэгтгэн тодорхойлох замаар бодлогын тулгамдсан асуудлын үр дагаврыг тодорхойлдог.

Эсрэгээрээ нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон

- Үндэсний хэрэгцээ, асуудлын шалтгаан нь Салбарын хэрэгцээ, асуудал
- Салбарын хэрэгцээ, асуудлын шалтгаан нь ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудал
- ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудлын шалтгаан нь Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ, асуудал болно.

ШИГТГЭЭ 5.

АСУУДЛЫН ШАЛТГААН:

Асуудлын шалтгаан гэдэг нь тулгамдсан асуудалд шууд нөлөөлж буй үзэгдэл, үйл явцыг хэлнэ.

Асуудлын шалтгааныг тодорхойлох үндсэн арга, аргачлал нь “асуудал”, “шалтгаан” хэмээн тодорхойлж буй үзэгдэл, үйл явцын хооронд шууд хамаарал байгаа эсэхийг тодорхойлох явдал юм.

Шалтгаан нь цаг хугацааны хувьд асуудлын өмнө үүснэ. Асуудал, шалтгаан хоорондын шууд хамаарлыг баримт, нотолгоонд үндэслэн тодорхойлно.

Бодлого боловсруулагчид бодлогын тулгамдсан асуудлын шалтгааныг тодорхойлохдоо гаргадаг нийтлэг алдаа, дутагдал нь хянагдахгүй хүчин зүйл, асуудалд нөлөөлж буй гадаад болон дам, хүчин зүйл, асуудлыг өдөөгч хүчин зүйл зэргийг асуудлын шалтгаан хэмээн тодорхойлох тохиолдол их байдаг. Энэ нь буруу шийдвэр гаргах үндэс болно. Жишээлбэл, Асуудлыг өдөөгч хүчин зүйл нь асуудлыг түр зуур намжаах, гал унтраах шинжтэй боловч урт хугацаандаа асуудлын хамрах хүрээг улам өргөжүүлэх шинжтэй байдаг.

Асуудлын шалтгааныг тодорхойлохдоо асуудлыг үүсгэж буй нийгмийн бүлгийн зан төлөв, үйлдлийг тодорхойлсны дараагаар тэрхүү зан төлөв, үйлдлийг сэдэлжүүлж буй хүчин зүйлийг тодорхойлно. Ингэснээр бодлогын асуудлын шалтгааныг тодорхойлох ажил бүрэн хийгдэнэ.

Асуудлын үндсэн шалтгааныг нарийвчлан тодорхойлохын тулд тулгамдсан асуудлыг үүсгэж буй нийт зорилтот бүлгийг адил төсөөтэй шинж чанараар нь ангилж бүлэглэн, тэдгээрийн онцлог хэрэгцээ шаардлагыг олж илрүүлэх нь ач холбогдолтой байдаг.

Нийт зорилтот бүлгийг адил төсөөтэй шинж чанараар ангилахын ач холбогдол нь ялгаатай бүлгүүдэд үүссэн асуудлын үндсэн шалтгааныг бодитоор тодорхойлоход тусална. Учир нь ангилсан бүлгүүдэд тулгарсан асуудал нь нэг боловч, шалтгаан нь өөр өөр байж болно.

Хэрэгцээ, асуудлын хоорондын уялдаа, хамаарлыг тодорхойлох дүн шинжилгээ нь асуудлын шалтгаан, үр дагаврын шинжилгээ бөгөөд энэ нь нийгэм болон оролцогч талд үүссэн хэрэгцээ, асуудлыг логик уялдаанд оруулж хоорондын уялдаа, хамаарлыг олж тогтоох, нэгтгэх, задлан шинжлэх үйл явц юм.

Асуудлын шалтгаан, үр дагаврын шинжилгээг

1. Босоо түвшний уялдаа, хамаарлын шинжилгээ
2. Хэвтээ түвшний уялдаа, хамаарлын шинжилгээ хэмээн ангилж болно.


Босоо түвшний уялдаа, хамаарлын шинжилгээ:

Үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн түвшний хэрэгцээ, асуудлын уялдаа, хамаарал нь босоо түвшний уялдаа, хамаарал болно.

Асуудлын шалтгаан, үр дагаврын шинжилгээний үр дүнг зурган дүрслэлээр нэг хавтгай дээр харах нь талуудад ойлгомжтой, хоорондын уялдаа хамаарлыг шууд харах боломжийг олгодог.

Өмнөх хэсэгт үндэсний түвшинд тодорхойлсон “Ядуурал түвшин өндөр, дундаж давхаргын хүрээ бага, ядуурал өртөх эрсдэл өндөр байна” гэсэн Үндэсний түвшний хэрэгцээ, асуудлын шалтгаант холбоог дараах зураглалаар үзүүлэв. Үүнд:


Зураг 8. Босоо түвшний шалтгаан, үр дагаврын шинжилгээний зураглал жишээ



Хэвтээ түвшний уялдаа, хамаарлын шинжилгээ:

Хэвтээ түвшний уялдаа, хамаарлын шинжилгээ нь нэг түвшний хэрэгцээ, асуудлын хоорондын уялдаа, хамаарлыг тооцох үндсэн арга зүй юм. Үүнийг дараах байдлаар зургаар илэрхийлэх боломжтой.

Зураг 9. Хэвтээ түвшний шалтгаан, үр дагаврын шинжилгээний зураглал



Босоо болон хэвтээ түвшний уялдаа, хамаарлыг тодорхойлохдоо нөлөөллийн хүчийг тооцох шаардлагатай. Нөлөөллийн хүчийг:

1. Хүчтэй эерэг хамааралтай
2. Сул эерэг хамааралтай
3. Хамааралгүй
4. Сул сөрөг хамааралтай
5. Хүчтэй сөрөг хамааралт гэсэн интервал ашиглаж болно.

Хэрэгцээ, асуудал хоорондын хамаарлыг тооцоход бүрэн хэмжээний өгөгдөл шаардлагатай бөгөөд өгөгдлийн найдвартай байдал хамгийн чухал. Энэхүү хамаарлыг улс орнууд программ хангамжийн тусламжтайгаар гүйцэтгэж, үр дүнг нэгдсэн зураглалаар гаргадаг.

“Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд ХНХС болон ХХААХҮС-ийн хариуцах салбарын нийт 15 асуудал тодорхойлсон бөгөөд тэдгээр асуудал хоорондын хамаарлыг хамааралтай бол “1”, хамааралгүй бол “0” гэсэн үзүүлэлтээр гаргасныг хавсралт 3-т үзүүлэв.

Алхам 4. Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратеги/-ыг тодорхойлох нь

Нөхцөл байдлын дүн шинжилгээний 4 дэх алхам нь “Асуудлыг шийдвэрлэх арга зам/ стратеги/-г тодорхойлох явдал байдаг. Асуудлыг шийдвэрлэх арга зам нь дээд шатны төлөвлөлтийг дараагийн шатны төлөвлөлттэй уялдуулах, төлөвлөлт хоорондын уялдааг хангах, үүсэх гажилтаас сэргийлэх, бодлого, төлөвлөлтийн залгамж чанар, тогтвортой байдлыг хангах чухал хэрэгсэл болдог.

“Арга зам /стратеги/” гэж үр дүнг хангахын тулд төрөөс баримтлах үндсэн зарчим, чиглэлийг хэлнэ. Өөрөөр хэлбэл “А” цэгээс “Б” цэгт ямар арга замаар хүрэх вэ? “А” цэгээс “Б” цэгт хүрэхдээ ямар зарчмыг баримтлах вэ? гэсэн хувилбарын сонголт юм. Жишээлбэл, Монгол Улсын Засгийн газраас салбарын түвшинд “халамжаас хөдөлмөр” гэсэн бодлогыг санал болгож байна. Энэ нь хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдэд халамж өгдөг байсан бол энэхүү хувилбарыг өөрчилж хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийг халамжийн бодлогын хамрах хүрээнээс үе шаттайгаар гаргаж “цаашид хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдэд халамж өгөхгүй” гэсэн зарчмыг тодорхойлж байна.

Арга замыг боловсруулахдаа хувилбартайгаар боловсруулж, хувилбарт тус бүрд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр сонголт хийж, сонгогдсон хувилбараа нэг мөр мөрдөж, сонгогдсон хувилбартаа нийцүүлэн дараагийн төлөвлөлтийг хийх зарчмыг мөрдөж ажиллахыг шаарддаг.

Арга замыг хувилбартайгаар боловсруулахын ач холбогдол нь хувилбарыг задлан шинжлэх үед бүх санал бодлыг харгалздагт, тэрчлэн асуудлыг шийдвэрлэх оновчтой арга замыг сонгох урьдач нөхцөлийг бүрдүүлдэгт оршино.

Бодлогын арга зам, хэрэгслийн хувилбаруудыг боловсруулсны дараагаар хийгдэх нэг чухал ажил нь “нөлөөллийн урьдчилсан үнэлгээ” юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд “нөлөөллийн урьдчилсан үнэлгээ” гэж бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны унаган төрх, тэнцвэрт байдал, түүнчлэн эрх зүйн орчин болон засаглалын тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг хэлнэ гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл “нөлөөллийн урьдчилсан үнэлгээ” нь бодлогыг тухайн хувилбараар хэрэгжүүлбэл ямар эерэг, сөрөг үр дагавар гарч болох вэ? гэдгийг урьдчилсан тооцно гэсэн үг. Энэ нь бодлогоос үүдэлтэй сөрөг үр дагаврыг урьдчилан харж, бодлогыг батлахаас өмнө нэмэлт зохицуулалт хийж, үүсэж болох сөрөг үр дагаврыг арилгах боломж олгодог.

Дараах хэсэгт нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон жишээг оруулав. Үүнд:

Хүснэгт 9. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон жишээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратегий/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
Үндэсний хэрэгцээ, асуудал						
Эдийн засгийн өгөөж	Нийт иргэд	Ядуурлын түвшин өндөр, дундаж давхаргын хүрээ бага, ядууралд өртөх эрсдэл өндөр байна	Иргэдийн хөдөлмөрийн оролцоог нэмэгдүүлэх			
Салбарын хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөр эрхлэлт (Бүх салбар)	Хөдөлмөрийн насны хүн ам	Хөдөлмөр эрхлэлт бага байна	Шинэ ажлын байр бий болгохыг дэмжих			
ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт (ХНХС)	Ажил олгогч ба ажиллах хүч	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдсан	Мэргэжлийн ажил эрхлэлтийг дэмжих			
Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа (ТЕЗ-ийн бодлого, удирдлага хөтөлбөр)	Судалгааны хэрэгцээ бүх талууд	Хөдөлмөрийн зах зээлийн урт, дунд, богино хугацааны эрэлтийг оновчтой таамаглаж чадахгүй байна	Салбарын судлаачдыг дэмжих			

Алхам 5. Асуудлыг хэмжих үзүүлэлт, асуудлын хамрах хүрээ, тархалтын хурдыг тодорхойлох нь

Нөхцөл байдлын дүн шинжилгээний 5 дахь алхам нь “Асуудлыг хэмжих үзүүлэлт, тархалтын хурд”-г тодорхойлох явдал байдаг. Үүнийг тодорхойлох нь тухайн хэрэгцээ, асуудлыг төрийн бодлогын хүрээнд авч үзэж шийдвэрлэх шаардлага, үндэслэлийг баталгаажуулдаг ач холбогдолтой.

Асуудлын хамрах хүрээ нь тухайн асуудал өртсөн нийт хүн ам, нийгмийн бүлэг, газар нутгийн хэмжээг илэрхийлдэг.

Асуудлын тархалтын хурд нь асуудлын хамрах хүрээ хэр зэрэг хурдтай өөрчлөгдөх вэ гэдгийг илэрхийлдэг.

Асуудлын хамрах хүрээг тодорхойлохын тулд түүнийг хэмжих үзүүлэлтийг боловсруулах ажил мөн хийгдэх шаардлагатай. Энэхүү үзүүлэлт нь бодлогын зорилго, зорилт буюу үр дүн тодорхойлох шатанд үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт болно.

Дараах хэсэгт нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд асуудлыг хэмжих үзүүлэлтийг тодорхойлсон жишээг оруулав. Үүнд:

Хүснэгт 10. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон жишээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратегий/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
Үндэсний хэрэгцээ, асуудал						
Эдийн засгийн өгөөж	Нийт иргэд	Ядуурлын түвшин өндөр, дундаж давхаргын хүрээ бага, ядууралд өртөх эрсдэл өндөр байна	Иргэдийн хөдөлмөр-ийн оролцоог нэмэгдүүлэх	- Ядуурлын түвшин -Дундаж давхарга - Дундаж давхаргын ядууралд өртөх эрсдэлийн түвшин		
Салбарын хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөр эрхлэлт (Бүх салбар)	Хөдөлмөрийн насны хүн ам	Хөдөлмөр эрхлэлт бага байна	Шинэ ажлын байр бий болгохыг дэмжих	Ажиллах хүчний оролцооны түвшин		

ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт (ХНХС)	Ажил олгогч ба ажиллах хүч	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдсан	Мэргэжлийн ажил эрхлэлтийг дэмжих	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү		
Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа (ТЕЗ-ийн бодлого, удирдлага хөтөлбөр)	Судалгааны хэрэгцээ бүх талууд	Хөдөлмөрийн зах зээлийн урт, дунд, богино хугацааны эрэлтийг оновчтой таамаглаж чадахгүй байна	Салбарын судлаачдыг дэмжих	Хөдөлмөрийн зах зээлийн урт, дунд, богино хугацааны эрэлтийн судалгааны нийц		

Асуудлын ирээдүйн дүр зургийг таамаглах:

Мөн энэ шатанд асуудлыг төрийн бодлогын хэмжээнд авч үзэж шийдвэрлээгүй тохиолдолд асуудлын ирээдүйн дүр зураг хэрхэн өөрчлөгдөхийг урьдчилан таамаглах шаардлага үүсдэг. Үүний тулд:

- Асуудлын ирээдүйн хамрах хүрээ
- Асуудлын ирээдүйн тархалтын хурд
- Асуудлаас ирээдүйд үүсэх үр дагавар
- Асуудлыг ирээдүйд шийдвэрлэхэд гарах зардлын өсөлт гэсэн үзүүлэлтийг ашиглах боломжтой.

Асуудлын ирээдүйн хамрах хүрээг өнгөрсөн үеийн асуудлын хамрах хүрээний өргөжилтийн дундажтай уялдуулан тооцно.

Асуудлын ирээдүйн тархалтын хурдыг өнгөрсөн үеийн асуудлын тархалтын дундаж хурдтай уялдуулан тооцно. Гэхдээ асуудлын дотоод зүй тогтолд өөрчлөлт гарахгүй гэсэн таамаглалтай үед үүнийг ашиглаж болно.

Асуудлаас ирээдүйд үүсэх үр дагаврыг өнгөрсөн хугацаанд дахь асуудлаас үүссэн үр дагаврын өргөжилт болон шинээр үүсэх үр дагаврыг урьдчилан таамаглаж тодорхойлно.

Асуудлыг ирээдүйд шийдвэрлэхэд гарах зардлын өсөлтийг үнийн өсөлт болон хугацаа алдаж шийдвэрлэснээс үүсэх нэмэлт зардлыг урьдчилан таамаглаж тодорхойлно.

Асуудлын эрэмбийн шинжилгээ

Асуудлыг шийдвэрлэх нөөц, боломжийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан асуудлыг эрэмбэлж хамгийн гол асуудалд төвлөрөх шаардлага тулгардаг.

Асуудлуудыг эрэмбэлж хамгийн гол асуудлыг сонгохдоо дараах шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэх боломжтой. Энэ нь зөвхөн доорх үзүүлэлтээр эрэмбэлэх шаардлагатай гэсэн үг биш бөгөөд нэмэлт шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж болно. Үүнд:

- Асуудлын хамрах хүрээ
- Асуудлын тархалтын хурд
- Асуудлаас үүсэх үр дагавар

Өмнөх хэсэгт “асуудлын хамрах хүрээ” нь тухайн асуудалд өртсөн нийт хүн ам, нийгмийн бүлэг, газар нутгийн хэмжээг илэрхийлдэг. “Асуудлын тархалтын хурд” нь асуудал ямар хурдтайгаар тархаж байна вэ? гэдгийг илэрхийлдэг. “Асуудлаас үүсэх үр дагавар” нь тухайн асуудал хөндлөн болон босоо чиглэл нийт хэдэн асуудалд шууд нөлөөлж байгааг илэрхийлдэг” талаар хөндсөн болно.

Асуудлын эрэмбийн шинжилгээг хийснээр асуудлын хамрах хүрээ хамгийн их, тархалт хамгийн хурдан, асуудлаас үүсэж буй үр дагавар хамгийн их асуудлыг нөөц боломжтой уялдуулан нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатайг харуулна.

Асуудлын хамрах хүрээ, тархалтын хурд, үр дагавраар нь асуудлуудыг эрэмбэлэх арга зүй болон “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд ХНХС болон ХХААХҮС-ийн эрхлэх асуудлын хүрээний нийт 22 асуудалд эрэмбийн шинжилгээ хийсэн жишээг хавсралт 4-д үзүүлэв.

Алхам 6. Тухайн түвшний хэрэгцээ, асуудлыг хангах үндсэн ба хамтрагч талуудыг тодорхойлох нь

Нөхцөл байдлын дүн шинжилгээний 6 дахь алхам нь “Тухайн түвшний хэрэгцээ, асуудлыг хангах үндсэн ба хамтрагч талууд”-г тодорхойлох явдал байдаг.

Үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн түвшинд тулгамдаж буй хэрэгцээ, асуудал нь нийт иргэд, нийгмийн тодорхой бүлгүүд болон тэдгээрийн зан төлөв, хандлага төлөвшил, үйлдэл эс үйлдлээс хамаарч бий болох боловч Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг төр, засгийн зүгээс тодорхойлж байгаа гэдэг үүднээс тухайн түвшний хэрэгцээ, асуудлыг хангах үндсэн ба хамтрагч талуудыг төрийн институци талаас, хариуцсан чиг үүрэгтэй уялдуулан тодорхойлох шаардлага үүсдэг.

Тухайн түвшний хэрэгцээ, асуудлыг хангах талуудыг тодорхойлох нь асуудлын шалтгааныг системтэй төлөвлөх, дараагийн шатны нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээг давхцал, хийдэлгүй тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Тухайн түвшний хэрэгцээ, асуудлыг хангах үндсэн ба хамтрагч талуудыг

- Үндэсний түвшинд хийж буй нөхцөл байдлын дүн шинжилгээний хувьд тодорхойлсон хэрэгцээ, асуудалд шууд нөлөөлөх салбараар
- Салбарын түвшинд хийж буй нөхцөл байдлын дүн шинжилгээний хувьд тодорхойлсон хэрэгцээ, асуудалд шууд нөлөөлөх ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд

- ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний түвшинд хийж буй нөхцөл байдлын дүн шинжилгээний хувьд тодорхойлсон хэрэгцээ, асуудалд шууд нөлөөлөх хөтөлбөрт үндэслэн тодорхойлно.

Дараах хэсэгт тухайн түвшний хэрэгцээ, асуудлыг хангах үндсэн ба хамтран хариуцагч талуудыг тодорхойлсон жишээг оруулав. Үүнд:

Хүснэгт 11. Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд асуудалд шууд холбогдогч талуудыг тодорхойлсон жишээ

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратеги/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
Үндэсний хэрэгцээ, асуудал						
Эдийн засгийн өгөөж	Нийт иргэд	Ядуурал түвшин өндөр, дундаж давхаргын хүрээ бага, ядууралд өртөх эрсдэл өндөр байна	Иргэдийн хөдөлмөрийн оролцоог нэмэгдүүлэх	- Ядуурлын түвшин -Дундаж давхарга - Дундаж давхаргын ядууралд өртөх эрсдэлийн түвшин		Бүх салбар
Салбарын хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөр эрхлэлт (Бүх салбар)	Хөдөлмөрийн насны хүн ам	Хөдөлмөр эрхлэлт бага байна	Шинэ ажлын байр бий болгохыг дэмжих	Ажиллах хүчний оролцооны түвшин		ХНХС
ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт (ХНХС)	Ажил олгогч ба ажиллах хүч	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдсан	Мэргэжлийн ажил эрхлэлтийг дэмжих	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт
Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа (ТЕЗ-ийн бодлого, удирдлага хөтөлбөр)	Судалгааны хэрэгцээ бүх талууд	Хөдөлмөрийн зах зээлийн урт, дунд, богино хугацааны эрэлтийг оновчтой таамаглаж чадахгүй байна	Салбарын судлаачдыг дэмжих	Хөдөлмөрийн зах зээлийн урт, дунд, богино хугацааны эрэлтийн судалгааны нийц		ХНХЯ-ны бодлого, төлөвлөлт-ийн газар

3.2. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ХҮРЭЭНД ГАРГАЖ БУЙ НИЙТЛЭГ АЛДАА БА ЗӨВЛӨМЖ

НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн арга зүйг нутагшуулах ажлын явцад хуримтлуулсан туршлага, сургамжид тулгуурлан “Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хүрээнд гаргаж буй нийтлэг алдаа ба зөвлөмж”-ийг дараах хэсэгт тусгав. Үүнд:

Нийтлэг алдаа №1: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцохдоо “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын санал, тооцооллыг нэгтгэн боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасан боловч холбогдох талуудаас ирүүлсэн нөхцөл байдлын дүн шинжилгээнд нэгтгэсэн дүн шинжилгээ хийхгүй байна.

Зөвлөмж: Батлагдсан аргачлалд нийцүүлэн “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн дүн шинжилгээг шууд дамжуулах, эсвэл хасах, эсвэл нэг файл болгож нэгтгэх бус нэгтгэн боловсруулах.

Нийтлэг алдаа №2: Мэдээллийн бэлэн байдал хангагдаагүй гэсэн шалтгаар хэрэгцээ, асуудлыг судалгаа, шинжилгээ, баримт нотолгоонд үндэслэн нөхцөл байдлын дүн шинжилгээг хийхгүй байна.

Зөвлөмж: Мэдээллийн бэлэн байдал хангагдаагүй боловч тухайн хэрэгцээ, асуудлыг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах шаардлагатай тохиолдолд мэдээллийн бэлэн байдлыг хангах ажил төлөвлөх, шалгуур үзүүлэлтийн нэгдсэн санд баталгаажуулж, статистик болон захиргааны мэдээлэл цуглуулах жагсаалтад оруулж ахиц дэвшил гаргах.

Нийтлэг алдаа №3: Төрийн захиргааны төв байгууллага нь нөхцөл байдлын шинжилгээ хийхдээ аймаг, орон нутгийн саналыг авч нөхцөл байдлын дүн шинжилгээндээ тусгадаггүй.

Зөвлөмж: Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар аймаг, орон нутгийн саналыг авч нөхцөл байдлын дүн шинжилгээнд тусгах, нөхцөл байдлын дүн шинжилгээнд тусгагдсан хэрэгцээ, асуудлыг аймаг, нийслэлээр ангилж тусгах.

Нийтлэг алдаа №4: Нөхцөл байдлын дүн шинжилгээг бодлогын орц, үйл ажиллагаа, гарцаар хязгаарладаг.

Зөвлөмж: Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт нь улс орны хэмжээнд хүлээгдэж буй ерөнхий хэрэгцээ, асуудлыг тодорхойлж, түүний шалтгааныг түвшнээр ялган шалтгаант холбоог тодорхойлсны дараагаар төрийн холбогдох байгууллагаас нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлдог. Үүний дараагаар үр дүн, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, үндсэн үйл ажиллагаа, төсвийн санхүүжилт хийгдэнэ гэдгийг оролцогч талууд зарчим болгох шаардлагатай.

Нийтлэг алдаа №5: Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхгүйгээр эсвэл хийсэн шинжилгээгээ хавсралтаар холбогдох талуудад илгээхгүй зөвхөн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгах саналаа ирүүлдэг.

Зөвлөмж: Аргачлалыг илүү сайжруулах шаардлагатай байгаа ба нөгөө талаас, батлагдсан аргачлалыг талууд мөрдөж ажиллах шаардлагатай. Мөрдүүлэх тал дээр УИХ, ЗГ, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага санаачилгатай ажиллах.

Нийтлэг алдаа №6: Өмнө хийгдсэн болон дээд эрэмбийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд хийгдсэн нөхцөл байдлын дүн шинжилгээг ашигладаггүй.

Зөвлөмж: Мэдээллийн сан үүсгэж, оролцогч талуудыг мэдээллээр хангах.

Нийтлэг алдаа №7: Нөхцөл байдлын дүн шинжилгээг батлагдсан аргачлалын хүрээнд шалтгаан, үр дагаврын холбоонд үндэслэн тодорхойлдоггүй, ерөнхий мэдээлэлд үндэслэн тайлан хэлбэрээр боловсруулдаг.

Зөвлөмж: Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхдээ нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ажлын хүснэгт болон асуудал, хэрэгцээний уялдааны зураглалыг ашиглаж хэвших.

Нийтлэг алдаа №8: Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхэд зарцуулах хугацаа, санхүүгийн нөөцийг төлөвлөдөггүй.

Зөвлөмж: Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхэд зарцуулах хугацааг оновчтой тооцож ажлыг эрт эхлүүлэх болон нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхэд шаардлагатай зардлыг төсөвт суулгаж баталдаг байх

3.3. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ХҮРЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ГАРЧ БҮЙ НИЙТЛЭГ АСУУЛТ БА ХАРИУЛТ

НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн арга зүйг нутагшуулах ажлын явцад оролцогч талуудаас “Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хүрээнд гарсан нийтлэг асуулт ба хариулт”-ыг дараах хэсэгт тусгав. Үүнд:

Нийтлэг асуулт №1: Нөхцөл байдлын дүн шинжилгээг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах болгондоо хийх үү? Ялангуяа жилийн хөгжлийн төлөвлөлт болон улсын төсөв батлах шатанд жил бүр хийх үү?

Хариулт: Улс орны түвшинд хүлээгдэж байгаа хэрэгцээ, асуудлыг 4 түвшинд хийж, шалтгаант холбоог бүрэн тодорхойлсон тохиолдолд дараа, дараагийн төлөвлөлтийн хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээг шинээр бус өмнө хийгдсэн шинжилгээнд суурилан сайжруулах замаар гүйцэтгэх боломжтой.

Нийтлэг асуулт №2: Үр дүнгийн шалгуур үзүүлэлт ба асуудлыг хэмжих үзүүлэлт 2 ижил зүйл үү? Ялгаатай зүйл үү?

Хариулт: Энэ 2 ижил зүйл. Бид нөхцөл байдлын шинжилгээ хийх хүрээнд тодорхойлсон асуудлыг эерэг өөрчлөлт болгон үр дүнг тодорхойлдог. Хэрэгцээ, асуудал буюу үр дүнг хэмжих л үзүүлэлт.

Нийтлэг асуулт №3: Үр дүнгийн шинжилгээний үе шатанд үр дүн, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулдаг. Яагаад нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх шатанд асуудлыг хэмжих үзүүлэлт тодорхойлох шаардлагатай вэ?

Хариулт: Практикт хэрэгцээ, асуудлаа тодорхойлоод дараагийн шатанд түүнийг үр дүн болгон хөрвүүлсний дараагаар энэхүү үр дүнгээ ямар шалгуур үзүүлэлтээр хэмжих вэ? гэсэн дарааллаар ажилладаг. Анхнаасаа хэрэгцээ, асуудлаа тодорхойлохдоо үүнийг ямар үзүүлэлтээр хэмжих вэ? гэдгийг хамт тодорхойлоод явах нь Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт байхгүй байна гэдэг асуудлаас сэргийлнэ.

Нийтлэг асуулт №4: Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын санал, тооцооллыг нэгтгэн боловсруулна гэж юуг хэлэх вэ?

Хариулт: Харьяа байгууллагуудаас ирүүлсэн дүн шинжилгээ, санал, тооцооллыг ижил шинж чанараар нэгтгэх, давхцал, хийдлийг арилгах, хоорондын шалтгаант холбоог нь олж тогтоон уялдуулах гэх мэт ажил хийхийг хэлнэ. Тэрнээс 1 файл болгох нь нэгтгэсэн гэсэн үг биш.

Нийтлэг асуулт №5: Шаардлагатай судалгаа, баримт нотолгоо байхгүй тохиолдолд яах вэ?

Хариулт: Тухайн асуудал нь урт, дунд хугацаанд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд тогтвортой хөндөгдөх шаардлагатай тохиолдолд логик уялдааны загварт үндэслэн дүн шинжилгээндээ тусгах ба цаашид тэрхүү асуудлын бусад асуудалтай уялдах уялдаа, хамаарлыг тодорхойлох судалгааг хийх ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх.

Нийтлэг асуулт №6: УИХ-д ажлаа хариуцан тайлагнадаг байгууллага болон шүүх засаглалын харьяа байгууллагууд яагаад нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгах санал өгөх шаардлагатай вэ?

Хариулт: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд нь нийт улс орны хэмжээнд хөгжлийн асуудлыг урт, дунд, богино хугацаагаар төлөвлөж, УИХ-аар баталдаг баримт бичгүүд юм. Тулгын гурван чулууны 2 чулуу нь байхгүй бол хөгжлийн бодлогыг нэгдмэл, цогц, харилцан уялдаатай төлөвлөж чадахгүй болно. Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь гүйцэтгэх засаглалд хамаарна. Бусад баримт бичгүүд нь гүйцэтгэх, шүүх, хууль тогтоох засаглалын нэгдсэн төлөвлөлт хийгдэх шаардлагатай баримт бичгүүд юм.

Нийтлэг асуулт №7: Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хугацаа байхгүйгээс бодитой, үр дүнтэй дүн шинжилгээ хийгдэж чадахгүй байна. Үүнийг хэрхэн шийдвэрлэх вэ?

Хариулт: Холбогдох журам, аргачлалуудад нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын санал, тооцооллыг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх эцсийн хугацааг л тодорхойлж өгсөн. Иймд идэвх, санаачилгатай ажиллаж аль болох эрт ажлыг эхлүүлэх боломж нь бүх оролцогч талуудад байгаа. Дээд байгууллагаас ирэх албан бичгийг хүлээгээд суугаад байх шаардлагагүй. Ажлыг эрт эхлүүл.

4 ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ

4.1. ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙ

Нөхцөл байдлын дүн шинжилгээг хийсний дараагаар бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдах үр дүнг тодорхойлох буюу үр дүнгийн шинжилгээг хийнэ.

Үр дүнгийн шинжилгээг нөхцөл байдлын дүн шинжилгээтэй адил үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, ТЕЗ-ийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийн гэсэн 4 түвшинд уялдуулан хийнэ.

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн үндсэн арга зүй нь өмнөх шатанд хийгдсэн, боловсруулсан зүйлс дараагийн шатны үндсэн эх сурвалж болох буюу хийгдэж буй үйл ажиллагаа, ажилбаруудыг хооронд нь уялдуулахад чиглэдэг.

Үр дүнгийн шинжилгээ нь нөхцөл байдлын дүн шинжилгээтэй харьцуулахад харьцангуй хялбар бөгөөд нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон хэрэгцээ, асуудлыг эерэг өөрчлөлт болгон хөрвүүлэх замаар боловсруулагддаг.

ЭЗХЯ-наас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах аргачлалуудад үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- “Үндэсний үр дүн” гэж улс оршин байх тулгуур үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;
- “Салбарын үр дүн” гэж үндэсний үр дүнг хангах тухайн салбарын тулгуур үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;
- “Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн” гэж салбарын үр дүнг хангах төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний үндсэн үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;
- “Хөтөлбөрийн үр дүн” гэж төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг хангах хөтөлбөр хэрэгжсэнээр бий болох эерэг өөрчлөлтийг;

Үр дүнгийн шинжилгээг дараах алхмын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

Алхам 1. Үр дүнг тодорхойлох

Алхам 2. Үр дүнд хүрэх арга зам /стратеги/-ыг тодорхойлох

Алхам 3. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь он, түвшин болон зорилтот он, түвшинг тодорхойлох

Алхам 4. Үр дүнг хангах үндсэн болон хамтран хариуцагчийг тодорхойлох

Алхам 5. Хөтөлбөрийн гарц, түүний шалгуур үзүүлэлтийг тодорхойлох

Үр дүнгийн шинжилгээг хийхдээ дараах ажлын хүснэгтийг ашиглах боломжтой. Үүнд:

Хүснэгт 12. Үр дүнгийн шинжилгээний ажлын хүснэгт

Үр дүн	Үр дүнд хүрэх арга зам /стратегии/	Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хариуцагч	
				Он	түвшин	Он	Түвшин	Үндсэн	Хамтрагч
				Үндэсний үр дүн					
				Салбарын үр дүн					
				ТЕЗ-ийн үр дүн					
				Хөтөлбөрийн үр дүн					

Нөхцөл байдлын дүн шинжилгээ болон үр дүнгийн шинжилгээ нь дараах байдлаар хоорондоо уялдах шаардлагатай. Үүнд:

Хүснэгт 13. Нөхцөл байдлын дүн шинжилгээ болон үр дүнгийн шинжилгээ хоорондын уялдаа

Дүн шинжилгээний хамрах хүрээ	Үр шим хүртэгч ба зорилтот бүлэг	Хэрэгцээ, асуудал	Асуудлыг шийдвэрлэх арга зам /стратегии/	Асуудлыг хэмжих үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ ба тархалтын хурд	Үндсэн ба хамтран хариуцагч талууд
Үндэсний хэрэгцээ, асуудал						
Салбарын хэрэгцээ, асуудал						
ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудал						
Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ, асуудал						


Үр дүн	Үр дүнд хүрэх арга зам /стратегии/	Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хариуцагч	
				Он	түвшин	Он	Түвшин	Үндсэн	Хамтрагч
Үндэсний үр дүн									
Салбарын үр дүн									
ТЕЗ-ийн үр дүн									
Хөтөлбөрийн үр дүн									

Алхам 1. Үр дүнг тодорхойлох нь

Үр дүнгийн шинжилгээний 1 дэх алхам нь “Үр дүн”-г тодорхойлох явдал байдаг. Энэ шатанд Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон хэрэгцээ, асуудлыг эерэг өөрчлөлт болгон хөрвүүлж бичнэ.

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн хэрэгцээ, асуудлыг үр дүн болгон хөрвүүлсэн жишээг дараах зургаар үзүүлэв.

Зураг 10. Үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнгийн жишээ



Энэхүү зураглалд Хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлснээр Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангана. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр хангагдсанаар Хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ. Хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэнээр Дундаж давхарга нэмэгдэнэ гэсэн логик хамаарлыг харуулж байна.

ШИГТГЭЭ 6.

БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ БА ҮР ДҮН:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд үр дүнг бодлогын үр нөлөө, зорилго, зорилт хэмээх ойлголтын хүрээнд тодорхойлохоор хуульчилсан.

Зорилго, зорилтыг энгийн байдлаар томъёолбол зорилго нь хүлээгдэж буй ерөнхий үр дүн бол зорилт завсрын үр дүн юм.

Бодлогын зорилго, зорилт хэмээх ойлголтыг үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүн гэсэн ойлголттой уялдуулан авч үзвэл дараах байдлаар харгалзуулж болно. Үүнд:

Үндэсний үр дүн – Бодлогын зорилго

Салбарын үр дүн – Салбарын зорилт

ТЕЗ-ийн үр дүн – ТЕЗ-ийн зорилт

Хөтөлбөрийн үр дүн – Хөтөлбөрийн зорилт

Алхам 2. Үр дүнд хүрэх арга зам /стратегии/-ыг тодорхойлох нь

Үр дүнгийн шинжилгээний 2 дахь алхам нь “Үр дүнд хүрэх арга зам”-г тодорхойлох явдал байдаг. Энэ шатанд Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон асуудлыг шийдвэрлэх арга замыг шууд авч ашиглана.

“Арга зам /стратегии/” гэж үр дүнг хангахын тулд төрөөс баримтлах үндсэн зарчим, чиглэлийг хэлнэ.

Арга зам нь бодлогын арга хэрэгслийг, сонголтыг чиглүүлж байдаг.

Бодлогын арга хэрэгсэл гэдэг нь тулгарсан асуудлыг шийдвэрлэж бодлогын зорилгыг хангахын тулд зорилтот бүлгийн хүмүүсийн хийхгүй байсан зүйлийг хийлгэх, эсвэл тэдний зан үйлийг өөрчлөх, оролцогч талуудын тэнцвэрт харилцааг зохицуулах зорилго бүхий элемент юм. Өөрөөр хэлбэл бодлогын арга хэрэгсэл нь нэгдүгээрт, бодлогын тулгамдсан асуудлын цаана байгаа зорилтот бүлгийн үйлдэл, эс үйлдэлд нөлөө үзүүлдэг. Хоёрдугаарт, төрийн холбогдох байгууллагын бодлогын зорилго, зорилтыг хангахын тулд хийх арга хэмжээний чиглэлийг тодорхойлж өгдөг хэрэгсэл юм.

Татвар, татаас, хөнгөлөлт, хориг /эдийн засгийн болон.../, журам, хууль, квот, сурталчилгаа, сургалт, урамшуулал, норм, норматив, стандарт тогтоох зэрэг бодлогын арга хэрэгсэл болдог.

Алхам 3. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь он, түвшин болон зорилтот он, түвшинг тодорхойлох:

Үр дүнгийн шинжилгээний 3 дахь алхам нь “Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь он, түвшин болон зорилтот он, түвшин”-г тодорхойлох явдал байдаг.

Энэ шатанд Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон асуудлыг хэмжих үзүүлэлтийг үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт болгон шууд авч ашиглана.

Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн хэрэгцээ, асуудлын хамрах хүрээг хэмжихээр сонгосон шалгуур үзүүлэлт нь үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт болно.

Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт гэж бодлогын хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон үзүүлэлтийг хэлэх бөгөөд тухайн бодлого төлөвлөсөн үр дүндээ хүрч байгаа эсэхийг харуулах, тайлагнах үндсэн мэдээлэл болно. Эндээс авч үзвэл шалгуур үзүүлэлт нь үр дүнг хэмжих хэмжүүр юм.

ШИГТГЭЭ 7.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Шалгуур үзүүлэлттэй холбоотой олон тодорхойлолтууд байдаг бөгөөд эдгээрээс хамгийн түгээмэл ашиглагддаг нь дараах хоёр тодорхойлолт юм. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтүүд нь амжилтыг хэмжих, хөндлөнгийн оролцоотой холбогдсон өөрчлөлтийг тусгах эсвэл тогтоосон үр дагаврыг байгууллагын гүйцэтгэлтэй харьцуулан үнэлэхэд туслах, хэмжихэд энгийн бөгөөд найдвартай аргаар хангадаг тоон болон чанарын хувьсах хэмжигдэхүүн байна.

Эх сурвалж: Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх 10 алхам, Жо Золл Кусек, Рей с.Рист

2. Шалгуур үзүүлэлт гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг хэлнэ.

Эх сурвалж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

Шалгуур үзүүлэлтийг сонгоход дараах 5 зүйлийг анхаарахыг НҮБ-ын Статистикийн комиссоос санал болгосон байна. Үүнд:

1. Хэмжиж байгаа зүйлийг **ТОДОРХОЙ** болгох үзүүлэлт мөн үү?
2. Үзүүлэлтийг **ХЭМЖИГДЭХҮЙЦ** байлгахын тулд өгөгдөл мэдээлэл нь бэлэн үү?
3. Хэмжих **НЭГЖ** нь тодорхой байна уу?
4. Хяналт тавих гэж байгаа асуудал хооронд хүчтэй **ХАМААРАЛ** байна уу?
5. Хэрхэн **ЗАДРАХ** нь нарийн тодорхойлогдсон уу?

Шалгуур үзүүлэлтийг сонгох үйл явц

1. Шалгуур үзүүлэлтийг боловсруулахын өмнө төлөвлөж буй үр дүн, гарцын үндсэн агуулгыг баталгаажуулна.
2. Одоо байгаа үзүүлэлтүүд болон олон улсад ашиглагддаг үзүүлэлтүүдийг цуглуулж сан бүрдүүлнэ. Одоо ашиглаж байгаа үзүүлэлтүүд тохиромжгүй, олон улсад ашиглаж байгаа үзүүлэлттэй холбоотой мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй байвал тохирох шалгуур үзүүлэлтийг шинээр боловсруулж санд нэмнэ.
3. Шалгуур үзүүлэлтийн сангаас үр дүн болон гарцад хамгийн тохиромжтой гэж үзсэн үзүүлэлтийн жагсаалт гаргана.
4. Жагсаалтаас эхний сонголт хийнэ. Сонголт хийхдээ сайн үнэлгээ авахын тулд хэрэгжүүлэхэд хялбар үзүүлэлт ашигласан эсэх, өгөгдлийг ашиглахад хялбар эсэх (тодорхой давтамжтай хэмжих боломжтой эсэх)-ийг шалгаж, оролцогч талуудтай хэлэлцэж, дүгнэх замаар сонгоно.
5. Үр дүнгийн болон гарцын үзүүлэлт хооронд давхцал, зөрчил байгаа эсэхийг шалгаж баталгаажуулна.
6. Шалгуур үзүүлэлтүүдийн өгөгдлийн бэлэн байдал, аргачлал, хариуцах эзэн, мэдээлэл цуглуулах зардал зэргийг тодорхойлно.

Судлаачид шалгуур үзүүлэлтийг

- Орцын
- Үйл ажиллагааны
- Гарцын
- Үр дагаврын
- Үр нөлөөний хэмээн ангилж авч үздэг.

Хүлээгдэж буй үр дүн гарахад тухайн хэрэгцээ, асуудлын онцлогоос шалтгаалан янз бүрийн /урт, дунд, богино/ хугацаа шаардлагатай байдаг. Иймд бодит өөрчлөлт гарахаас өмнө зөв чиглэлд өөрчлөлт гарч байгаа, гарах эсэхийг урьдчилан тогтоохын тулд дан ганц эцсийн буюу үр дагаврын, үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг ашиглахаас гадна орц, үйл явцын, гарцын шалгуур үзүүлэлтийг бодлогын хэрэгжилтийн хугацаатай уялдуулан ашиглах шаардлага үүсдэг.

Энэ нь төлөвлөсөн орцыг оруулсан тохиолдолд бодлогын үйл явц зөв явагдаж байна, төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн тохиолдолд бодлогын үйл явц зөв явагдаж байна, төлөвлөсөн гарцыг нийлүүлсэн тохиолдолд төлөвлөсөн үр дагавар гарна, төлөвлөсөн үр дагавар бий болсон тохиолдолд бодлогын үр нөлөө хангагдана гэсэн дүгнэлтийг хийхэд ач холбогдолтой байдаг.

Практикт үр дүн болон шалгуур үзүүлэлтийг андуурч хэрэглэх тохиолдол гардаг бөгөөд энэ хоёр ойлголтын хооронд тодорхой ялгаа байдгийг анхаарах хэрэгтэй.

Хүснэгт 14. Үр дүн ба шалгуур үзүүлэлтийг ялгааг харуулсан жишээ

Үр дүн	Шалгуур үзүүлэлт
Таны хүрэх гэж байгаа зүйлийн тодорхойлолт бөгөөд ихэвчлэн "өсгөх", "сайжруулах", "багасгах" гэх мэт нэр томъёог ашигладаг. Үүнд "50 хувиар бууруулах" гэх мэт амжилтын хэмжүүр багтаж болох бөгөөд хамгийн гол нь ажилтад хүрэх хугацааг тодорхойлсон байх ёстой.	Үр дүн нь биелж байгаа эсвэл биелэх магадлалтай эсэхийг тодорхойлохын тулд санал болгож буй хэмжих үзүүлэлт.
ТХЗ: Зорилт 3.1 2030 он гэхэд 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийг 70-аас доош болгож бууруулна.	ТХЗ: Шалгуур үзүүлэлт 3.1.1 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн харьцаа

Тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг хэр чанартай боловсруулсан эсэхийг нягтлах хяналтын хуудсыг хавсралт 5-д оруулав.

Суурь болон зорилтот түвшин:

Ирээдүйн үр дүнгийн гүйцэтгэлийг хэмжих эхлэлийн цэг, эсвэл чиглүүлэгчээр суурь түвшнийг хэрэглэдэг. Суурь түвшин нь бодлогын эхлэх үеийн, эсвэл эхлэхээс дөнгөж

өмнөх үеийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн талаарх тоон болон чанарын мэдээлэл юм.

Зорилтот түвшин нь тухайн цаг хугацаанд хүлээгдэж буй /хүрэхээр зорьж байгаа/ үр дүнг тоо болон чанараар илэрхийлсэн түвшин бөгөөд тодорхой цаг хугацаанд ямар ахиц өөрчлөлтөд хүрч болохыг илэрхийлнэ.

Үр дүн, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин нь ХШҮ-ний бүрэлдэхүүн хэсгийг төлөөлдөг. Суурь болон зорилтот түвшин нь үр дүн эсвэл гүйцэтгэлийн түвшинг хэмжихэд ашигладаг үзүүлэлттэй шууд холбоотой байдаг. Хэрэгжилтийн явцыг тодорхойлохын тулд суурь (эхлэх цэг) түвшинг тогтоодог. Суурь түвшний тусламжтай гүйцэтгэлийг одоо болон өмнөх үетэй харьцуулдаг.

Зорилтот түвшинг

- Хэрэгцээ, асуудлын тархалтын хурд
- Хэрэгцээ, асуудлын уялдаа хамаарлын шинжилгээ
- Үр дүнг хангахад зарцуулах боломжтой нөөцийн тооцоолол зэрэгт үндэслэн тодорхойлдог.

Зорилтот түвшинг илүү бодитой тодорхойлохын тулд өнгөрсөн хугацааны хэрэгцээ, асуудлын тархалтын хурдад үндэслэн дараах 5 чиглэлээс сонгох боломжтой.

- Хэт өөдрөг таамаглал
- Өөдрөг таамаглал
- Дундаж
- Дунджаас доогуур таамаглал
- Зогсонги байдал

Бодлогын зорилго, зорилтын буюу үр дүнгийн зорилтот түвшинг тодорхойлох үндсэн зарчим нь боломжоос тодорхой түвшинд давсан байдлаар тодорхойлж, түүндээ хүрэхийн тулд бүх нөөц боломжийг шахаж ажиллахад чиглэдэг.

Алхам 4. Үр дүнг хангах үндсэн болон хамтран хариуцагчийг тодорхойлох нь

Үр дүнгийн шинжилгээний 4 дэх алхам нь “Үр дүнг хангах үндсэн болон хамтран хариуцагч”-г тодорхойлох явдал байдаг. Энэ шатанд Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон тухайн түвшний хэрэгцээ, асуудлыг хангах үндсэн ба хамтрагч талуудад үндэслэн үндсэн болон хамтран хариуцагчийг тодорхойлно.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хувьд үр дүнг хариуцах үндсэн болон хамтрагч нь тухайн үр дүнг шууд бий болгох үүргийг хүлээж байгаа гэсэн үг биш юм. Өөрөөр хэлбэл тэрхүү үр дүнгийн төлөө хамтын хариуцлага хүлээнэ. Энэхүү үр дүн нь дан ганц тухайн асуудлыг хариуцсан төрийн холбогдох талаас хамаарахгүй түүнд хамаарал бүхий бүх талуудын хамтын хүчин чармайлтын үр дүнд хангагдана.

ЭЗХЯ-аас баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах

аргачлалуудад үр дүнг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт дараах загвартайгаар тусгахаар зохицуулсан. Үүнд:

Хүснэгт 15. Үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин

№	Бодлогын үндэслэл	Салбар/ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Мэдээллийн үзүүлэлтүүд				
						он	Түвшин		Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага	
Үндэсний үр дүн													
Салбарын үр дүн													
ТЕЗ-ийн үр дүн													
Хөтөлбөрийн үр дүн													

Дээрх хүснэгтийг дараах байдлаар бөглөнө.

- “Бодлогын үндэслэл” баганад үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнд хамаарах дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилтын дугаарыг бичнэ.
- “Салбар/ТЕЗ/Хөтөлбөрийн нэр” баганад тухай үр дүнг хариуцах салбар, Төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөрийн нэрийг бичнэ.
- “Үр дүн” баганад үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнг нөхцөл байдлын шинжилгээний хүрээнд боловсруулсан хэрэгцээ, асуудлыг эерэг өөрчлөлт болгон хөрвүүлж бичнэ.
- “Шалгуур үзүүлэлт”, “Хэмжих нэгж” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон хэрэгцээ, асуудлын хамрах хүрээг хэмжих шалгуур үзүүлэлтийг хуулж бичнэ.
- “Суурь түвшин” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, урьдчилсан гүйцэтгэлийн хүрсэн түвшинд үндэслэн суурь түвшнийг тодорхойлж бичнэ.
- “Зорилтот түвшин” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, суурь түвшинд үндэслэн зорилтот түвшнийг тодорхойлж бичнэ.
- “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийн мэдээллийн бэлэн байдлыг өгөгдсөн үзүүлэлтийн дагуу тодорхойлж бичнэ.
- Шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг үр дүнг хангахад шаардлагатай санхүүжилтийн дүнтэй уялдуулан тодорхойлно.

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн хүрээнд тодорхойлсон үр дүн нь SMART зарчмыг хангасан эсэхийг нягтлах шаардлагатайг судлаачид зөвлөдөг. Үүнд:

S	Specific	Тодорхой байх
M	Measurable	Хэмжигдэхүйц байх
A	Achievable	Хүрч болохуйц байх
R	Relevant	Хамааралтай байх
T	Time-bound	Цаг хугацаатай

Үр дүнг тодорхойлох SMART зарчим болон нөхцөл байдлын дүн шинжилгээ, үр дүнгийн шинжилгээ хоорондоо уялдааг хангаж боловсруулсан эсэхийг нягтлах хяналтын хуудсыг хавсралт 6-д үзүүлэв.

Алхам 5. Хөтөлбөрийн гарц, түүний шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь

Үр дүнгийн шинжилгээ хийж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд хүлээгдэж буй үр дүн, үр дүнд хүрэх арга замыг тодорхойлсны дараагаар хийгдэх нэг чухал алхам нь Үндэсний, Салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн үр дүнг хангах хөтөлбөрийн гарцыг тодорхойлох алхам байдаг.

“Хөтөлбөрийн гарц” гэж хөтөлбөрийн үр дүнг хангахад чиглэсэн төрийн байгууллага болон бусад этгээдээс нийлүүлэх эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ юм.

Хөтөлбөрийн гарц нь үр дүнд суурилсан төлөвлөлт болон үр дүнд суурилсан төсөвлөлтийг холбох холбоос болдог.

Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэх гарц нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хөтөлбөрийн үр дүнг хангахад шууд чиглэсэн байх;
2. Үр шим хүртэгчид буюу хүн амын тодорхой зорилтод бүлэгт чиглэсэн байх (байгууллагын дотоод хэрэгцээ, үйл ажиллагаанд бус гадагшаа чиглэсэн байх);
3. Төсөв захирагчийн холбогдох хуульд заасан чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байх;
4. Хяналт тавих боломжтой байх (гарцын нийлүүлэлтийн талаар хариуцлага хүлээх боломжтой байх);
5. Хэмжиж болохуйц байх (гарцыг үнэлж, дүгнэх, цаг хугацааны явцад харьцуулах боломжтой байх);

Хөтөлбөрийн гарцыг нийлүүлэхийн тулд холбогдох төрийн байгууллагууд нь үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэг. Эдгээр ойлголтыг дараах байдлаар тодорхойлох боломжтой.

- “Үндсэн үйл ажиллагаа” гэж төрийн байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчийн хариуцсан үр дүнгээ хангах буюу мандатаа хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай багц арга хэмжээг
- “Төсөл” гэж хөтөлбөрийн үр дүн гарахад хувь нэмэр оруулахаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт эсвэл нэг удаагийн багц арга хэмжээг
- “Арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг;

Тухайн ТЕЗ-ийн хариуцаж буй салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн хүрээнд хүлээгдэж буй үр дүнг бодит биелэлт болгож чадах эсэх нь үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлт болон үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, бүрдүүлэх, зарцуулахаас шууд хамаарна.

Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо шалгуур үзүүлэлтэд тавигдах нийтлэг шаардлагыг харгалзан үзэж боловсруулна.

Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний гарцын үзүүлэлт нь хөтөлбөрийн гарц болно.

Хөтөлбөрийн гарцын суурь болон зорилтот түвшинг тодорхойлохдоо ТЕЗ-ийн харьяалах төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчдын хуулиар хүлээсэн ижил төрлийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нэгтгэх замаар гаргана. Хөтөлбөрийн гарцын шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо тоо шалгуур үзүүлэлтээс илүү чанарын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь үр дүнг бодит биелэлт болгоход шууд нөлөөлдөг.

Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв
- Гадаадын зээл
- Тусламж
- Төр, хувийн хэвшлийн түншлэл
- Хувийн хэвшил
- Бусад эх үүсвэр хэмээн ангилж болно.

ҮДСНУ-ын нэг гол үзэл баримтлал нь үр дүн болон гарцыг хангахад дан ганц төрийн институци биш холбогдох талуудыг оролцуулах, санхүүжилтийн бусад эс үүсвэрийг татан төвлөрүүлэхэд чиглэдэг. Иймд үндсэн үйл ажиллагаа, арга хэмжээ энэхүү чиглэлийг баримжаалж тодорхойлогдох нь чухал.

Хөтөлбөрийн гарц нь цаашид холбогдох төрийн байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, улс орон нутгийн төсөв боловсруулах суурь болно.

4.2. ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ХҮРЭЭНД ГАРГАЖ БУЙ НИЙТЛЭГ АЛДАА БА ЗӨВЛӨМЖ

НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн арга зүйг нутагшуулах ажлын явцад хуримтлуулсан туршлага, сургамжид тулгуурлан “Үр дүнгийн шинжилгээ хийх хүрээнд гаргаж буй нийтлэг алдаа ба зөвлөмж”-ийг дараах хэсэгт тусгав. Үүнд:

Нийтлэг алдаа №1: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт ТЕЗ-ийн үр дүн болон ТЕЗ-ийн санхүүжилт авч буй хөтөлбөрийн үр дүнг бүрэн тусгахгүй байна. Батлагдсан баримт бичигт огт үр дүн тусгагдаагүй ТЕЗ-ийн төсөв болон хөтөлбөр байсаар байна. Энэ нь хөгжлийн бодлого, төлөвлөлт болон төсөв хоорондын уялдаа алдагдах, ТЕЗ-ийн харьяа байгууллагууд хариуцсан чиг үүргийнхээ төлөө тууштай ажиллах хүчин чармайлтыг саармагжуулах, ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын үйл ажиллагааг санхүүжүүлж буй төсвийн санхүүжилтийн үр дүн, үр ашгийг тооцох боломжгүй болох зэрэг олон сөрөг үр дагавартай.

Зөвлөмж: Иймд батлагдсан аргачлалыг нэг мөр мөрдөх

Нийтлэг алдаа №2: Үр дүн тодорхойлсон боловч үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт тодорхойлохгүй байх. Хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй. Зөвхөн чиглэл заасан үр дүнг SMART зарчмыг хангасан гэж үзэх үндэслэл болохгүй. Энэ нь цаашид хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гэх мэт төрийн удирдлагын дараагийн үе шатнуудад сөргөөр нөлөөлж, эцсийн үр дүн хангагдах боломжгүй болно

Зөвлөмж: Үр дүн бүрд тохирсон шалгуур үзүүлэлт тодорхойлох

Нийтлэг алдаа №3: Үр дүнг хавсарсан болон энгийн нийлмэл өгүүлбэрээр багцалж тодорхойлох. Арга хэмжээ, үйл ажиллагаа, үр дүн, үр дүнд хүрэх арга замыг нийлмэл өгүүлбэр нэгтгэж, хольж хутгаж томъёолох нь тодорхойгүй, хоёрдмол утгатай, логикийн алдаа үүсэх, хариуцлага эзэнгүйдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Зөвлөмж: Нэг үр дүн нэг томъёолол зарчмыг мөрдөх. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт нь үр дүнг түвшнээр ялгаж, үр дүн, үр дүнд хүрэх арга зам, гарц, үйл ажиллагааг түвшин түвшинд нь уялдуулан тодорхойлох зарчим үндэслэдэг.

Нийтлэг алдаа №4: Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд хөндөгдсөн асуудал, бодлогын баримт бичигт туссан үр дүн хоорондоо зөрөх.

Зөвлөмж: Нөхцөл байдлын дүн шинжилгээнд хөндөгдөөгүй асуудлыг үр дүн болгож томъёолохгүй байх

Нийтлэг алдаа №5: Үр дүн хоорондын логик уялдаа алдагдах.

Зөвлөмж: Шалтгаант холбоог нягтлах. Хөтөлбөрийн үр дүн хангагдвал ТЕЗ-ийн үр дүн хангагдана. ТЕЗ-ийн үр дүн хангагдвал салбарын үр дүн хангагдана. Салбарын үр дүн хангагдвал Үндэсний үр дүн хангагдана гэсэн шаталсан шууд хамаарал үр дүн хооронд байх ёстой гэдгийг анхаарах

Нийтлэг алдаа №6: Үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт хоорондоо зөрөх. Өөрөөр хэлбэл үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо тухайн үр дүнг хэмжихгүй өөр үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт тодорхойлох, үр дүнг гарцын үзүүлэлтээр хэмжих, үр дагаврыг үр нөлөөний үзүүлэлтээр хэмжих гэх мэт.

Зөвлөмж: Үр дүнгийн хүрээ, шалгуур үзүүлэлтийн хэмжилтийн хүрээ 2 давхцах шаардлагатай. Өөрөөр хэлбэл Ямар үр дүн тодорхойлсон тэр л үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлох

Нийтлэг алдаа №7: Зорилтот түвшинг боломжоос хэт өндөр эсвэл хэт амархан хэрэгжих боломжтойгоор тодорхойлох.

Зөвлөмж: Өнгөрсөн жилүүдийн үр дүнгийн өөрчлөлтийн дундаж болон санхүүжилттэй уялдуулан аль болох бодитой тодорхойлохыг эрмэлзэх.

Нийтлэг алдаа №8: Шалгуур үзүүлэлтийг үр дүн, гарц эсвэл үйл ажиллагаа байдлаар томъёолох.

Зөвлөмж: Шалгуур үзүүлэлт нь үр дүнг хэмжих хэмжүүр гэдгийг анхаарах. Шалгуур үзүүлэлт бол үр дүн ч биш, үйл ажиллагаа ч биш.

Нийтлэг алдаа №9: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт 4 түвшний үр дүнгийн зарим түвшинг тусгахгүй орхигдуулдаг.

Зөвлөмж: Батлагдсан аргачлалыг нэг мөр мөрдөх

4.3. ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ХҮРЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДААС ГАРЧ БҮЙ НИЙТЛЭГ АСУУЛТ БА ХАРИУЛТ

НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн арга зүйг нутагшуулах ажлын явцад оролцогч талуудаас “Үр дүнгийн шинжилгээ хийх хүрээнд гарсан нийтлэг асуулт ба хариулт”-ыг дараах хэсэгт тусгав. Үүнд:

Нийтлэг асуулт №1: Яагаад үр дүнг 4 түвшинд авч үзэх шаардлагатай вэ?

Хариулт: Улс орны хэмжээнд хүлээгдэж буй ерөнхий үр дүн юу вэ? Түүнд салбаруудын оруулах хувь нэмэр юу вэ? Салбарын асуудлыг үүсгэж буй зорилтот бүлэгт ямар үйлдэл, эс үйлдэл хийгдээд байна вэ? Үйлдэл, эс үйлдлийг сэдэлжүүлж буй шалтгаан юу вэ? гэсэн 4 түвшинд асуудлыг нарийвчилж асуудлын үндсэн шалтгааныг илрүүлэхэд 4 түвшин байх нь илүү оновчтой байна.

Нийтлэг асуулт №2: 4 түвшний үр дүнг хэн тодорхойлох нь илүү оновчтой вэ?

Хариулт: Үндэсний болон салбарын үр дүнг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад талуудын саналд үндэслэн тодорхойлох. ТЕЗ-ийн болон хөтөлбөрийн үр дүнг тухайн асуудлыг хариуцсан ТЕЗ бусад талуудын саналд үндэслэн тодорхойлох.

Нийтлэг асуулт №3: Улсын болон орон нутгийн төлөвлөлтийн баримт бичигт тодорхойлогдох үр дүн хоорондоо ялгаатай байх ёстой юу? Ижил байх ёстой юу?

Хариулт: Ижил байх шаардлагатай учир нь аймаг, нийслэлийн нийлбэр нь улс болно. Ингэхдээ орон нутгийн ТЕЗ-д олгогдсон эрх, үүргийг харгалзах шаардлагатай. Улсын төлөвлөлтийг хийхдээ үр дүнгүүдийг аймаг, нийслэлээр ангилж харж чаддаг байх шинэчлэлийг нэвтрүүлэх шаардлагатай.

Нийтлэг асуулт №4: Хөгжлийн бодлого, төлөвлөлт ба байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөлт хоорондоо хэрхэн уялдах вэ?

Хариулт: Хөтөлбөрийн үр дүн, хөтөлбөрийн гарцаар хоорондоо холбогдох шаардлагатай. Хөгжлийн бодлого, төлөвлөлт нь улс болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үр дүн, гарцыг нийт дүнгээр нэгтгэн тодорхойлж байгаа бол байгууллагын төлөвлөлт нь тэрхүү үр дүн, гарцыг манай байгууллагын нийлүүлэх хэсэг нь аль хэсэг вэ? гэсэн зарчмаар цааш нарийвчилна.

Нийтлэг асуулт №5: Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт болон мэдээллийн бэлэн байдал хангагдаагүй бол яах вэ?

Хариулт: Мэдээллийн бэлэн байдлыг хангах ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх. Тэр болтол түр орлуулах шалгуур үзүүлэлт байгаа эсэхийг нягтлах. Шалгуур үзүүлэлтийн сан үүсгэж ажиллах

Нийтлэг асуулт №6: Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт болон мэдээллийн бэлэн байдал хангагдаагүй бол яах вэ?

Хариулт: Мэдээллийн бэлэн байдлыг хангах ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх. Тэр болтол түр орлуулах шалгуур үзүүлэлт байгаа эсэхийг нягтлах. Шалгуур үзүүлэлтийн сан үүсгэж ажиллах

ХАВСРАЛТ 1: САНАЛ БОЛГОЖ БУЙ САЛБАРЫН ЖАГСААЛТ БА ТОДОРХОЙЛОЛТ

Төрийн удирдлага:

Төрийн ерөнхий удирдлагын хүрээнд хууль тогтоох, гүйцэтгэх бүрэлдэхүүний хэрэгжүүлэх чиг үүргийн багц/функцийн/ багц юм. Энэ салбарт төрийн ерөнхий удирдлагын бүх чиг үүргийг хамруулна. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь засаглалын шалгуур үзүүлэлт байна.

Харин энэ салбарт гадаад харилцаа, батлан хамгаалах, эдийн засгийн үйл хэргийн бүрэлдэхүүн хамаарахгүй. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтүүд болох тохируулгын чанар, улс төрийн тогтвортой байдал, засгийн газрын үр нөлөө, Дэлхийн өрсөлдөх чадварын үзүүлэлтүүд болох макро эдийн засгийн тогтвортой байдал, бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөх чадвар, гадаад худалдааны нээлттэй байдал зэрэг байна.

Гадаад харилцаа:

Гадаад харилцаанд хамаарах чиг үүргийн багц юм. Улс орны тусгаар тогтнол бүрэн эрхт байдлын гадаад орчинд баталгаажуулах, Монгол Улсын иргэний эрхийг бусад улс оронд хамгаалах, гадаад эдийн засгийн харилцааг тогтворжуулах гэх мэт чиг үүргүүд хамаарна. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь Даяаршлын үзүүлэлт байна.

Батлан хамгаалах:

Улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг цэргийн хүчээр сахин хамгаалах чиг үүргийн багц юм. Ерөнхийдөө бусад улс орны хатуу гадаад бодлогын сөрөн зогсох дотоод, гадаад чадавхыг бэхжүүлэх чиг үүргийг бүхэлд нь хамаарсан салбар юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Батлан хамгаалах чадавх байна.

Хууль, дотоод хэрэг:

Нийгмийн дэг журмыг сахин хамгаалах чиг үүргийн багц юм. Иргэн, хуулийн этгээдийн эрхийг сахин хамгаалах, нийгмийн дэг журмыг сахиулах, Иргэн, хуулийн этгээдийн үүргийн биелэлтийг хангуулах гэх мэт чиг үүрэг хамаарна. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтүүд болон авлигын индекс, хуулийн засаглал, иргэдийн дуу хоолой ба хариуцлага, Дэлхийн өрсөлдөх чадварын үзүүлэлт болох өмчийн эрхийн хамгаалал болон гэмт хэрэг, зөрчил, осол гэмтлийн тоо зэрэг байна.

Санхүү:

Улс орны санхүүгийн харилцааг бүрэн зохицуулан удирдах чиг үүргийн багц юм. Санхүүгийн харилцаанд холбогдох талуудын харилцааны шударга байдлыг бэхжүүлэх, улс орны санхүүгийн дотоод зах зээлийн тэнцвэржилтийг хангах, санхүүгийн гадаад зах зээлтэй үр дүнтэй харилцааг бэхжүүлэх гэх мэт чиг үүрэг хамаарна. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Компанийн засаглалын үзүүлэлт /Дэлхийн өрсөлдөх чадварын үзүүлэлт/, санхүүгийн болон даатгалын салбарын нэмэгдэл өртөг зэрэг байна.

Хөдөлмөр эрхлэлт:

Иргэн, иргэний харьяалалгүй этгээдийн хөдөлмөрлөх эрх, үүргийн зохицуулалтыг удирдах, иргэний орлогын тогтвортой байдлыг бэхжүүлэх, салбарын судалгаа,

хөгжүүлэлтийн үр дүнг удирдах чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Зохистой хөдөлмөр эрхэлж байгаа хүн болон ажиллагчдын дундаж цалин байна.

Хөдөө аж ахуй:

Хөдөө аж ахуйн үйл хэргийг дэмжих, холбогдогч талуудын эрх үүргийн тэнцвэржүүлэх, үйлдвэрлэлийн орлогын тогтвортой байдлыг хангах, судалгаа, хөгжүүлэлтийн үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эзлэх хувь байна.

Эрчим хүч:

Улс орны эрчим хүчний тогтвортой хангамжийг дэмжих чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь эрчим хүчний тэнцэл, үр ашиг байдлын үзүүлэлтүүд байна.

Уул уурхай:

Ашигт малтмалын эрэл хайгуул, зохистой олборлолт, ашиглалтыг удирдах чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Уул уурхайн салбарын нэмэгдэл өртөг байна.

Боловсруулах үйлдвэрлэл:

Боловсруулах үйлдвэрлэлийн үр дүн, үр ашгийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь ДНБ-д боловсруулах үйлдвэрлэлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь байна.

Барилга:

Үйлдвэрлэл үйлчилгээний барилгажилт болон орон сууцны үр дүнтэй ашиглалт, бүтээн байгуулалтыг дэмжих чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Орчны эрсдэлийн түвшин байна.

Зам, тээвэр:

Улс орны зам тээврийн үр дүн, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх чиг үүргийн багц юм. Тухайлбал, зам тээврийн харилцааны холболтын үр дүн үр ашгийн тасралтгүй нэмэгдүүлэх, түүнд холбогдох судалгаа, хөгжлийн ажлын үр дүнг нэмэгдүүлэх гэх мэт чиг үүрэг үүнд хамаарна. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Логистикийн гүйцэтгэлийн индекс байна.

Мэдээлэл, харилцаа холбоо:

Иргэний харилцаа холбооны үр дүн үр ашгийг нэмэгдүүлэх чиг үүргийн багц юм. Тухайлбал харилцаа холбооны бүтээгдэхүүн үйлчилгээний нэгжийн зардлыг бууруулах, чанарыг сайжруулах, түүнд холбогдох судалгаа, хөгжлийн үр дүнг нэмэгдүүлэх чиг үүрэг хамаарна. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Цахим засаглалын хөгжлийн индекс байна.

Хүнс:

Иргэдийн эрүүл аюулгүй хүнсний хангамж, хэрэглээг зохицуулах чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Хүнсний аюулгүй байдлын индекс байна.

Аялал жуулчлал:

Жуулчин, үйлчилгээ үзүүлэгч этгээдийн үр дүнтэй, үр ашигтай зохистой харилцааг хөгжүүлэх чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Хүлээн авах гадаад жуулчдын тоо болон Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекс байна.

Худалдаа:

Монгол Улсын иргэн, харьяалалгүй этгээд, хуулийн этгээдийн хоорондын бөөний болон жижиглэнгийн худалдааны үр дүнтэй үр ашигтай байдлыг хангах чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Худалдааны салбарын нэмэгдэл өртөг байна.

Үйлчилгээний бусад:

Үйлчлүүлэгч болон үйлчлэгчийн хоорондын зөв харилцааг бэхжүүлэх чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Үйлчилгээний бусад салбарын нэмэгдэл өртөг байна.

Байгаль орчны хамгаалал:

Байгаль хүний зөв хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, үе хоорондын зөв ашиглалтыг бэхжүүлэх чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Орчны чанарын үзүүлэлт, Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн нийт хэмжээ, түүний менежментийн үр ашигт байдлын үнэлгээ, нийт усны хэрэглээнд газрын доорх усны эзлэх хувь, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ, доройтсон газар нутгийн хэмжээ, ургамал болон амьтны зүйлийн тоо, хүлэмжийн хийн ялгарал зэрэг байна.

Эрүүл мэнд:

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугчдын эрүүл амьдрах, эрүүл мэндийн шаардлагатай үйлчилгээг чанартай хүртээмжтэй авах бодит боломжийг бүрдүүлэх чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Нас баралтын түвшин / төрлүүдээр/, Халдварт өвчний тархалт, эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлагыг хангасан эмийн эзлэх хувь, Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эмийн эзлэх хувь, "Хэвийн" биеийн жинтэй эзлэх хувь зэрэг байна.

Соёл:

Монгол Улсын уламжлалт соёлын зөв хөгжлийн дэмжих, бусад улс орны зөв соёлын шингээн авах харилцааг зохицуулах чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Үндэсний соёлын нэгдмэл зүйлийн индекс, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь зэрэг байна.

Боловсрол:

Монгол Улсын иргэдийн бүх шатны боловсролын үйлчилгээг чанартай хүртээмжтэй авах бодит боломжийг бүрдүүлэх чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Бага насны хүүхдийн хөгжлийн индекс, бүх шатны боловсролын байгууллагын мэргэжлийн багшийн хангалт, бага болон суурь боловсролын чанарын үнэлгээ, олон улсад магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын эзлэх хувь, инженерийн чиглэлээр төгсөгчдийн нийт МСҮТ төгсөгчдөд эзлэх хувь, дэлхийн шилдэг 1000 их сургуулийн чансаанд багтсан их сургууль зэрэг байна.

Нийгмийн хамгаалал:

Нийгмийн харилцаанд бие даан бүрэн оролцох боломжгүй иргэдийн эрхийг хамгаалах, шаардлагатай үйлчилгээг хүргэх чиг үүргийн багц юм. Үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь Өндөр насны дундаж тэтгэвэр, ажиллагчдын дундаж цалингийн харьцаа, нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшний дундажтай харьцуулсан харьцаа, хүн амын жилийн дундаж өсөлт, гэр бүл цуцлалт, хүүхдийн эрхийн индекс зэрэг байна.

ХАВСРАЛТ 2: ХЭРЭГЦЭЭ, АСУУДЛЫГ ТҮВШНЭЭР ЯЛГАЖ ТОДОРХОЙЛСОН ЭСЭХИЙГ ШАЛГАХ ХУУДАС

Үндэсний, салбарын, ТЕЗ-ийн, хөтөлбөрийн түвшинд тулгамдсан хэрэгцээ, асуудлыг оновчтой тодорхойлсон эсэхийг шалгах хуудас

Шалгах асуулт	Үзүүлэлт	Утга	Оноо
Үндэсний түвшний хэрэгцээ/асуудал мөн үү?	Улс, үндэстний оршихуйн үндэс буюу салгашгүй шинжид шууд нөлөөлдөг хэрэгцээ/асуудал мөн эсэх	тийм/үгүй	1/0
	Хэд хэдэн салбарын хэрэгцээ/асуудлаас шууд хамааралтайгаар бий болдог хэрэгцээ/асуудал мөн эсэх	тийм/үгүй	1/0
Салбарын түвшний хэрэгцээ/асуудал мөн үү?	Үндэсний хэрэгцээ/ асуудалд шууд нөлөөлдөг хэрэгцээ/асуудал мөн эсэх	тийм/үгүй	1/0
	Тухайн салбарын үндсэн хэрэгцээ/асуудал мөн эсэх	тийм/үгүй	1/0
	Хэд хэдэн ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ/асуудлаас шууд хамааралтайгаар бий болдог хэрэгцээ/асуудал мөн эсэх	тийм/үгүй	1/0
ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ/асуудал мөн үү?	Салбарын хэрэгцээ/ асуудалд шууд нөлөөлдөг хэрэгцээ/асуудал мөн эсэх	тийм/үгүй	1/0
	Салбарын асуудлыг үүсгэж буй нийгмийн бүлгийн зан төлөв, үйлдэлд тулгарч буй хэрэгцээ/асуудал мөн эсэх	тийм/үгүй	1/0
	Хэд хэдэн хөтөлбөрийн түвшний хэрэгцээ/асуудлаас шууд хамааралтайгаар бий болдог хэрэгцээ/асуудал мөн эсэх	тийм/үгүй	1/0
Хөтөлбөрийн түвшний хэрэгцээ/асуудал мөн үү?	ТЕЗ-ийн хэрэгцээ/ асуудалд шууд нөлөөлдөг хэрэгцээ/асуудал мөн эсэх	тийм/үгүй	1/0
	ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нийгмийн бүлгүүдийн хэрэгцээ/асуудлыг сэдэлжүүлж буй орчин (дотоод, гадаад) нөхцөл мөн эсэх;	тийм/үгүй	1/0
	Хөтөлбөрийн хэд хэдэн гарцаас шууд хамааралтайгаар бий болдог хэрэгцээ/асуудал мөн эсэх	тийм/үгүй	1/0

ХАВСРАЛТ 3: САЛБАРЫН ХЭРЭГЦЭЭ, АСУУДАЛ ХООРОНДЫН ХЭВТЭЭ ТҮВШНИЙ УЯЛДАА, ХАМААРАЛ /ХНХС, ХХААХҮС-ИЙН ЖИШЭЭН ДЭЭР/

Салбарын үр дүн		2.1	2.2	2.3	4.2	4.3	4.4	5.1	6.5	7.8	10.1	10.2	11.2	11.3	11.5	11.6	Нийт
2.1. Дундаж цалинг 9.3 хувиар нэмэгдүүлнэ.	2.1	0	1	0	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	4
2.2. Зохистой хөдөлмөр эрхэлж буй хүний тоог 40 мянгаар нэмэгдүүлнэ.	2.2	1	0	0	1	1	1	0	0	0	0	0	1	1	1	1	8
2.3. Тэтгэврийн дундаж хэмжээг ажиллагчдын дундаж цалингийн 33 хувиас бууруулахгүй.	2.3	0	0	0	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	3
4.2. Гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг хангана.	4.2	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	2
4.3. Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.	4.3	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1
4.4. Нийгмийн онцлог бүлгүүдийн ялгаатай хэрэгцээний хангалтыг нэмэгдүүлнэ.	4.4	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	2
5.1. Хүнсний аюулгүй байдлыг 7.6 хувиар сайжруулна.	5.1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
6.5. Цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд өртсөн газрыг 22.9 хувьд тогтоон барина.	6.5	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
7.8. Төрийн бүтээмжийн сэргэлт	7.8	1	1	1	1	1	1	1	1	0	1	1	1	1	1	1	14
10.1. Бизнесийн шинэ санааг дэмжих инновацийн орчны хөгжлөөр эхний 85 орны нэг болно.	10.1	1	1	1	0	0	0	0	0	1	0	1	1	1	1	1	9
10.2. Инновацийн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах чадвараар эхний 80 орны нэг болно.	10.2	1	1	1	0	0	0	0	0	1	1	0	1	1	1	1	9

11.2. Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг 22.5 хувиар нэмэгдүүлнэ.	11.2	1	1	1	0	0	0	1	0	0	0	0	0	1	1	1	7
11.3. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын нэмүү өртгийг 44.6 хувиар нэмэгдүүлнэ.	11.3	1	1	1	0	0	0	1	0	0	0	0	1	0	1	1	7
11.5. Худалдааны салбарын нэмүү өртгийг 20.8 хувиар нэмэгдүүлнэ.	11.5	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	1	5
11.6. Үйлчилгээний салбарын нэмүү өртгийг 10.5 хувиар нэмэгдүүлнэ.	11.6	1	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	0	5
15		8	8	7	6	6	5	3	1	2	2	2	5	7	7	7	76

Жич: Энэхүү шинжилгээ нь логик дүгнэлт дээр тулгуурлан хийсэн хийсвэр тооцоолол болно.

Энэхүү хүснэгтийн мөр нь тухайн хэрэгцээ, асуудалд нөлөөлөх хэрэгцээ, асуудлыг илэрхийлж байгаа бол багана нь тухайн хэрэгцээ, асуудлаас хамаарах хэрэгцээ, асуудлыг харуулж байна.

ХАВСРАЛТ 4: АСУУДЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ТАРХАЛТЫН ХУРД, ҮР ДАГАВРААР НЬ АСУУДЛЫГ ЭРЭМБЭЛЭХ АРГА ЗҮЙ БОЛОН ЖИШЭЭ

Асуудлын хамрах хүрээ, тархалтын хурд, үр дагавраар нь асуудлыг эрэмбэлэхдээ энэхүү үзүүлэлтэд тоон утга оноож, онооны систем рүү шилжүүлж, дундаж утгыг гарган эрэмбэлнэ. Үүнийг 1-10 хүртэлх онооны систем рүү шилжүүлбэл дараах тоон утгыг оноож болох юм.

Асуудлыг эрэмбэлэх шалгуур үзүүлэлт ба түүний утга

Шалгуур үзүүлэлт	Асуудлын хамрах хүрээ:	Асуудлын тархалтын хурд:	Асуудлаас үүсэх үр дагавар:	
			Урт хугацааны бодлоготой хамааралтай байдал:	Ижил түвшний асуудалд нөлөөлөх байдал:
Утга	1. Зорилтот бүлгийн 100-91 хувийг хамрах асуудал бол 2. Зорилтот бүлгийн 90-81 хувийг хамрах асуудал бол 3. Зорилтот бүлгийн 80-71 хувийг хамрах асуудал бол 4. Зорилтот бүлгийн 70-61 хувийг хамрах асуудал бол 5. Зорилтот бүлгийн 60-51 хувийг хамрах асуудал бол 6. Зорилтот бүлгийн 50-41 хувийг хамрах асуудал бол 7. Зорилтот бүлгийн 40-31 хувийг хамрах асуудал бол 8. Зорилтот бүлгийн 30-21 хувийг хамрах асуудал бол	1. Асуудлын хамрах хүрээ сүүлийн 3-5 жилийн хугацаанд дунджаар 5.1-ээс дээш хувиар өссөн бол 2. Асуудлын хамрах хүрээ сүүлийн 3-5 жилийн хугацаанд дунджаар 4.1-5 хувиар өссөн бол 3. Асуудлын хамрах хүрээ сүүлийн 3-5 жилийн хугацаанд дунджаар 3.1-4 хувиар өссөн бол 4. Асуудлын хамрах хүрээ сүүлийн 3-5 жилийн хугацаанд дунджаар 2.1-3 хувиар өссөн бол 5. Асуудлын хамрах хүрээ сүүлийн 3-5 жилийн хугацаанд дунджаар 1.1-2 хувиар өссөн бол 6. Асуудлын хамрах хүрээ сүүлийн 3-5 жилийн хугацаанд дунджаар 0-1 хувиар өссөн бол 7. Асуудлын хамрах хүрээ сүүлийн 3-5 жилийн хугацаанд дунджаар 0.1-1 хувиар буурсан бол 8. Асуудлын хамрах хүрээ сүүлийн 3-5 жилийн хугацаанд	1. Үндэсний болон салбарын 19-өөс дээш асуудалтай шууд хамааралтай бол 2. Үндэсний болон салбарын 17-18 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол 3. Үндэсний болон салбарын 15-16 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол 4. Үндэсний болон салбарын 13-14 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол 5. Үндэсний болон салбарын 11-12 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол 6. Үндэсний болон салбарын 9-10 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол 7. Үндэсний болон салбарын 7-8 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол 8. Үндэсний болон салбарын 5-6 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол	1. Хөндлөн чиглэлд 19-өөс дээш асуудалтай шууд хамааралтай бол 2. Хөндлөн чиглэлд 7-18 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол 3. Хөндлөн чиглэлд 15-16 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол 4. Хөндлөн чиглэлд 13-14 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол 5. Хөндлөн чиглэлд 11-12 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол 6. Хөндлөн чиглэлд 9-10 хүртэл асуудалтай шууд

9. Зорилтот бүлгийн 20-11 хувийг хамрах асуудал бол	10. Зорилтот бүлгийн 10-1 хувийг хамрах асуудал бол	дунджаар 1.1-2 хувиар буурсан бол	9. Үндэсний болон салбарын 3-4 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол	7. Хөндлөн чиглэлд 7-8 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол
		9. Асуудлын хамрах хүрээ сүүлийн 3-5 жилийн хугацаанд дунджаар 2.1-3 хувиар буурсан бол	10. Үндэсний болон салбарын 2 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол	8. Хөндлөн чиглэлд 5-6 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол
		10. Асуудлын хамрах хүрээ сүүлийн 3-5 жилийн хугацаанд дунджаар 3.1-ээс дээш хувиар буурсан бол		9. Хөндлөн чиглэлд 3-4 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол
				10. Хөндлөн чиглэлд 2 хүртэл асуудалтай шууд хамааралтай бол

“Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд ХНХС болон ХХААХҮС-ийн жишээн дээр ТЕЗ-ийн нийт 22 асуудлыг тодорхойлсон бөгөөд тэдгээр асуудлын эрэмбийн шинжилгээг дараах хүснэгтээр үзүүлэв.

ТЕЗ-ийн түвшний хэрэгцээ, асуудлын эрэмбийн шинжилгээ
/ХНХС, ХХААХҮС-ийн жишээн дээр/

ТЕЗ-ийн үр дүн	Асуудлын хамрах хүрээ	Асуудлын тархалтын хурд	Урт хугацааны бодлоготой хамааралтай байдал	ТЕЗ-ийн үр дүнд шууд нөлөөлөх байдал	Нийт оноо	Эрэмбэ
7.8.1.Төрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ (ХНХЯ)	10	9	7	10	36	I
7.8.1.Төрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ (ХХААХҮЯ)	10	9	6	10	35	II
2.2.2.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангана.	9	7	7	6	29	III
2.1.1. Салбарын бодит хөдөлмөрийн бүтээмжийг 14 хувиар нэмэгдүүлнэ.	8	8	6	4	26	IV
11.2.2.Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ.	7	7	6	6	26	IV
2.3.2.Нийгмийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлнэ	10	9	2	3	24	V
2.2.1.Ажлын байрны тоог 10 мянгаар нэмэгдүүлнэ.	5	6	6	6	23	VI
10.2.1.Барааны тэмдгийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ.	5	6	6	6	23	VI
11.5.1.Нийт худалдааны эргэлтэд цахим худалдааны эзлэх хувийн жинг 20 хувиар нэмэгдүүлнэ.	6	9	4	4	23	VI
11.3.2.Хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг 33 хувиар нэмэгдүүлнэ.	3	8	5	6	22	VII
4.4.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний суурь эрхийг хангана.	10	7	3	1	21	VIII
10.1.1.Зах зээлд нэвтрүүлсэн шинэ бараа, бүтээгдэхүүний тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	6	3	6	6	21	VIII
11.2.1.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд эрчимжсэн аж ахуйн бүтээгдэхүүний эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлнэ.	4	5	6	6	21	VIII
5.1.1.Хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамжийг 4 хувиар нэмэгдүүлнэ.	10	6	4	0	20	IX
4.2.1.Гэр бүлийн эерэг харилцааг бэхжүүлнэ.	7	5	3	2	17	X

6.5.1.Бэлчээрийн даац хэтрэлтийг 5 хувиар бууруулна.	7	10	0	0	17	X
11.6.1.Үйлчилгээний экспорт хийдэг аж ахуйн нэгж, иргэний тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	5	4	4	4	17	X
2.3.1.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийн жилийн дундаж өгөөжийг 5 хувьд хүргэнэ.	4	6	3	3	16	XI
4.3.1.Зорилтот бүлгийн иргэдийн бие даан амьдрах чадварыг сайжруулна.	5	7	3	1	16	XI
4.4.3.Оюутан, залуучуудын нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлнэ.	7	5	3	1	16	XI
5.1.2. Хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшинг 10 хувиар бууруулна	7	7	1	0	15	XII
4.4.1.Эрүүл, идэвхтэй ахмад настныг нэмэгдүүлнэ.	5	5	3	1	14	XIII

Жич: Энэхүү шинжилгээ нь логик дүгнэлт дээр тулгуурлан хийсэн хийсвэр тооцоолол болно

ХАВСРАЛТ 5: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХЭР ЧАНАРТАЙ БОЛОВСРУУЛСАН ЭСЭХИЙГ НЯГТЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Шалгуур үзүүлэлтийн боловсруулалтын чанарыг шалгах хуудас

№	Шалгах асуулт	Үзүүлэлт	Утга	Оноо
1	Оновчтой буюу хэмжих ёстой зүйлээ хэмжиж байна уу?	Шалгуур үзүүлэлт нь үр дүн, гарцыг бодитоор хэмжиж чадаж байгаа эсэх	тийм/үгүй	1/0
2	Хэмжих нэгж нь тодорхой юу?	Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгж нь оновчтой эсэх	тийм/үгүй	1/0
3	Шалгуур үзүүлэлтийг зорилтот бүлгээр задалж болох уу?	Асуудлыг шийдэхээр зорьсон зорилтот бүлэг эсвэл гарцын шинж чанараас хамааран шалгуур үзүүлэлтийг задалж болж байгаа эсэх	тийм/үгүй	1/0
4	Тодорхой буюу мэдээллийн эх сурвалж юу вэ?	Мэдээллийн эх сурвалж нь тодорхой эсэх	тийм/үгүй	1/0
5	Хялбар буюу мэдээлэл цуглуулах арга нь тодорхой юу?	Мэдээллийг цуглуулж боловсруулах олон арга байдаг бол аль аргыг ашиглаж хэн цуглуулахыг тодорхойлсон эсэх	тийм/үгүй	1/0
6	Найдвартай буюу мэдээллийг хэр тогтмол цуглуулах вэ?	Мэдээллийн давтамж нь тогтмол эсэх /нэг удаагийн судалгаа үнэлгээний үр дүн биш байх эсвэл тухайн аргачлалаар өөр судлаач мэдээллийг цуглуулахад ижил үр дүн гарах боломжтой эсэх/	тийм/үгүй	1/0
7	Мэдрэг буюу өөрчлөлт гарсан тохиолдолд хэмжих боломжтой юу?	Шалгуур үзүүлэлт нь нөхцөл байдал сайжирсан эсвэл доройтсоныг илтгэж чадах эсэх	тийм/үгүй	1/0
8	Хэрэгцээтэй буюу цуглуулсан мэдээлэл нь шийдвэр гаргахад хэрэгтэй юу?	Мэдээллийг авах нь оролцогч талуудад хийж байгаа зүйлээ илүү сайн, үр дүнтэй хийхэд нөлөөлөх эсэх	тийм/үгүй	1/0
9	Мэдээллийг цуглуулахад ямар зардал гарах вэ?	Тухайн мэдээллийг цуглуулах шаардлагатай зардлыг төсөвт тусгаж шийдвэрлэсэн эсэх	тийм/үгүй	1/0
Нийт /боловсруулалтын чанар/			сайн/муу	7/0

ХАВСРАЛТ 6: ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛОХ SMART ЗАРЧИМ БОЛОН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ ХООРОНДЫН УЯЛДААГ ХАНГАЖ БОЛОВСРУУЛСАН ЭСЭХИЙГ НЯГТЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Боловсруулсан хөтөлбөрийн үр дүнгээ дараах асуулт, үзүүлэлтийн дагуу шалгаж боловсруулалтын чанарыг үнэлнэ. Үүнд:

№	Шалгах асуулт	Үзүүлэлт	Утга	Оноо
1	Нөхцөл байдлын дүн шинжилгээний хүрээнд тодорхойлсон хэрэгцээ, асуудалтай уялдсан уу?	Нөхцөл байдлын шинжилгээний хүрээнд тодорхойлсон хэрэгцээ, асуудлыг үр дүн болгож хөрвүүлсэн эсэх	тийм/үгүй	1/0
2	Дээд эрэмбийн бодлогын үр дүнтэй уялдсан уу?	Салбарын үр дүн нь үндэсний үр дүнтэй уялдаатай эсэх, ТЕЗ-ын үр дүн нь салбарын үр дүнтэй уялдсан эсэх, Хөтөлбөрийн үр дүн нь ТЕЗ үр дүнтэй уялдсан эсэх	Тийм/үгүй	1/0
3	Эерэг өөрчлөлтийг илэрхийлсэн үү?	Суурь түвшин, зорилтот түвшинг тодорхойлох эсэх	тийм/үгүй	1/0
4	Тодорхой байна уу?	Логик алдаагүй, хоёрдмол утгагүй энгийн, ойлгомжтой тодорхойлсон эсэх	тийм/үгүй	1/0
5	Хэмжиж болохуйц байна уу?	Эерэг өөрчлөлтийг хэмжих шалгуур үзүүлэлт, түүний мэдээллийн бэлэн байдал хангагдсан эсэх	тийм/үгүй	1/0
6	Бодитой, хүрч болохуйц байна уу?	Хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг тооцсон эсэх	тийм/үгүй	1/0
7	Хамааралтай, үр дүнг илэрхийлсэн байна уу?	Үр шим хүртэгч болон бусад оролцогч талын бодит хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон эсэх	тийм/үгүй	1/0
8	Хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон байна уу?	Суурь он, зорилтот оныг тодорхойлсон эсэх	тийм/үгүй	1/0
Нийт /боловсруулалтын чанар/			сайн/муу	8/0

